

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-50

1.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	7-33
2.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	33-46
3.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг	46-49
4.Хуулийн төсөл эцэслэн батлах	49-50
5.Хуулийн эцсийн найруулга сонсох	50

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 03-ны өдөр /Мягмар гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 76 гишүүн хүрэлцэн ирж, 60.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Х.Баасанжаргал, Б.Батбаатар, О.Батнайрамдал, Ш.Бямбасүрэн, Т.Доржханд, Г.Лувсанжамц, Ч.Номин, С.Одонтуяа, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Сандаг-Очир, Х.Тэмүүжин, Д.Цогтбаатар, Б.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: П.Батчимэг, А.Ганбаатар, С.Лүндэг, Н.Номтойбаяр;
Чөлөөтэй: Ж.Галбадрах, Ч.Ундрэм;

Тасалсан: Х.Баттулга;

Хоцорсон: С.Амарсайхан- 16 минут, Ч.Анар- 03 минут, Э.Бат-Амгалан- 09 минут, Д.Батбаяр- 26 минут, Б.Батцэцэг- 07 минут, Э.Батшугар- 03 минут, Ж.Бат-Эрдэнэ-1 цаг 07 минут, Ж.Баясгалан- 03 минут, Г.Ганбаатар- 13 минут, Д.Ганбат- 06 минут, Л.Гантөмөр- 57 минут, Б.Жаргалан- 13 минут, Д.Жаргалсайхан- 02 минут, С.Замира- 01 минут, Б.Заяабал- 08 минут, Л.Мөнхбаатар- 02 минут, Т.Мөнхсайхан- 36 минут, П.Мөнхтулга- 20 минут, З.Мэндсайхан- 35 минут, О.Саранчулуун- 01 минут, Ц.Туваан- 22 минут, Б.Тулга- 12 минут, Г.Тэмүүлэн- 03 минут, Н.Учрал- 18 минут, Г.Уянгахишиг- 01 минут, Б.Чойжилсүрэн- 1 цаг 11 минут, Ж.Энхбаяр- 1 цаг 14 минут, Р.Эрдэнэбүрэн- 34 минут.

Нэг.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Солонгоо, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, дэд дарга Ү.Амарбат, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Д.Энхтүвшин, С.Ганбаатар, О.Цогтгэрэл, Д.Үүрийнтуяа, Ц.Мөнхбат, Ж.Золжаргал, Ж.Чинбүрэн, Ж.Баясгалан, Б.Заяабал,

Б.Жаргалан нарын тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Сангийн сайд Б.Жавхлан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Л.Мөнхбаясгалан, С.Ганбаатар, Д.Батлут, Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан нар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 94

Татгалзсан: 11

Бүгд: 105

89.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Нэгдсэн хуралдаан 11 цаг 33 минутаас 12 цаг 15 минутад завсарлав.

Хоёр.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Солонгоо, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа, Б.Түвшин, Д.Батбаяр нарын тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 32¹ дүгээр зүйлийн 32¹.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32¹.5.Энэ хуулийн 32¹.1-д заасан төсвийн төслийг Улсын Их Хурал ажлын 7 хоногт багтаан, аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дээд шатны төсвийг баталснаас хойш ажлын 5 хоногт багтаан хэлэлцэж, дараагийн төсвийн ажил эхлэхээс өмнө батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал гаргасан саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан тайлбар хийв.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Д.Амарбаясгалан: 2.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 32¹ дүгээр зүйлийн 32¹.2, 32¹.3 дахь хэсгийн “нэгдсэн” гэснийг хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Сангийн сайд Б.Жавхлан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 47
Бүгд: 105
55.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 32¹ дүгээр зүйлийн 32¹.4 дэх хэсгийн “8.4, 8.5 дахь хэсэг” гэснийг “8.4, 8.5 дахь хэсэгт заасан хугацаа,” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 53
Бүгд: 105
49.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Батцэцэг дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Б.Батцэцэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 49
Бүгд: 105
53.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 53
Бүгд: 105
49.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 48
Бүгд: 105
54.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 45
Бүгд: 105
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Нэгдсэн хуралдаан 12 цаг 59 минутаас 13 цаг 10 минутад завсарлав.

Гурав.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Солонгоо, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын

дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Ж.Алдаржавхлан нарын тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн хариулж, тайлбар хийв.

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 13 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Хуулийн төслийг эцэслэн батлах

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Солонгоо, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Д.Амарбаясгалан: Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 77

Татгалзсан: 28

Бүгд: 105

73.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн энэ өдрийн нэгдсэн хуралдаанаар Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг сонсох горимын санал гаргав.

Улсын Их Хурлын гишүүдийн олонх дээрх горимын саналыг дэмжив./13:20/

Тав.Баталсан хуулийн эцсийн найруулга сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Солонгоо, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./13:24/

Уг асуудлыг 13 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, Ш.Мөнхцоож, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 2 цаг 31 минут үргэлжилж, 126 гишүүнээс 105 гишүүн хүрэлцэн ирж, 83.3 хувийн ирцтэйгээр 13 цаг 24 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өглөөний амгаланг айлтгая.

75 гишүүн ирцэд бүртгэгдэж, 76 гишүүн бүртгэгдэж, 60,3 хувьтай байна. Өнөөдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 3 асуудлыг хэлэлцэнэ.

1 дүгээрт, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

2 дугаарт, Төсвийн байнгын хорооны хуралдаанаар анхны хэлэлцүүлэг хийсний дараа Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

3 дугаарт, Төсвийн байнгын хорооны хуралдаанаар эцсийн хэлэлцүүлэг хийсний дараа Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Ингээд хэлэлцэх асуудалд оръё.

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Бейсен гишүүн гарч утсаар ярих уу.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Индэрт урья.

Б.Жавхлан: Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоомжийг хүчингүй болгосон ба үүнтэй холбогдуулан Хууль тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоол баталсан.

Уг тогтоолоор Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан болно.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт заасан төсвийн цаглаврын дагуу жилийн төсвийн төслийг Засгийн газрын 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор батлахаар тус тус заасан байдаг.

Харин Улсын Их Хурал улсын төсөв, Ирээдүй өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тухай хуулийг хуульд заасан үндэслэлээр хүчингүй болгосон тохиолдолд Засгийн газраас төсвийн төслийг дахин боловсруулж, өргөн мэдүүлэх тусгайлсан зохицуулалт байхгүй тул уг харилцааг зохицуулсан хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар жилийн төсвийн төслийг Засгийн газар дахин боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх эрх зүйн орчин бүрдэх юм.

Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхланд баярлалаа.

Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцэхээр Улсын Их Хурлын чуулгын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэсэн бөгөөд Төсвийн байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явууллаа.

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр баталсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь хориг тавьсан хоригийг Улсын Их Хурал 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоомжийг хүчингүй болгосон бөгөөд үүнтэй холбогдуулан хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 47 дугаар тогтоолыг баталсан. Уг тогтоолоор Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасны дагуу жилийн төсвийн төслийг Засгийн газар дахин боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, төсвийн төсөлд тусгах өөрчлөлтийн хүрээг тусгасан Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл Засгийн газраас жилийн төсвийн төслийг дахин боловсруулж өргөн мэдүүлэхдээ төсвийн төслийн танилцуулга, тооцоолол, судалгааг Төсвийн

тухай хуулийн дагуу өргөн мэдүүлсэн нэгдсэн төсөвт үндэслэн боловсруулж, холбогдох өөрчлөлтийг тусгасан байх бөгөөд төсвийн нийт зарлага, алдагдлын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төслийг аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ тухайн шатын төсвийн төслийг дараагийн төсвийн жил эхлэхээс өмнө хэлэлцэн батлах өөрчлөлтийг тусгасан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн аймаг, нийслэл, сум, дүүрэг, тухайн шатын төсвийн төслийг батлах цаглаврын талаар болон төсвийг буцаасан тохиолдолд Засгийн газар дахин өргөн мэдүүлж, батлах үндэслэлийг хуулийн хүчингүй болгохоос бусад бүх нөхцөлийг тусгах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар жилийн төсөвт Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьсан тохиолдолд Улсын Их Хурал төсвийг дахин хэлэлцэх дэгийн зохицуулалтыг бий болгох, Улсын Их Хурлын гишүүн Батжаргал хуулийн төслийг дэмжиж байгаа бөгөөд төсвийн төслийг Улсын Их Хурал аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ тухайн шатын төсвийн төслийг батлах,, цаглаврыг нарийвчлан тооцох, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл, Заяабал нарт жилийн төсвийн төслийг өргөн мэдүүлэх хэлэлцэн батлах, зохицуулалтыг боловсронгуй болгох талаар холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах нь зүйтэй талаар асуулт асууж, үг хэлсэн бөгөөд Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Баярсайханы Солонго ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асууж хариулт авна.

Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууна.

Н.Наранбаатар: Гишүүдэд өглөөний мэнд хүргэе. Хуулийн төслийг ер нь дэмжиж байгаа. Өөр бид гарц байхгүй байх гэж бодож байгаа. Тэгээд Байнгын хорооны даргаас асууя.

Хэрвээ Улсын Их Хурал төсвөө батлах явц нь хойшлогдоод оны эцэс рүү шахагдаад, ингээд он 12 сарын 30-нд ч юм уу, 29 гээд баталчихдаг. Дараа нь нөгөө аймаг маань, тэгээд сумууд маань батална. Тэгээд он гараад явчихвал яах вэ?

Нэгжийн хууль дээр 36.1.2-т заачихсан байгаа шүү дээ. Хугацаандаа баталж чадаагүй бол иргэдийн хурал нь тарна гээд, бүрэн бүрэлдэхүүнээрээ. Тэгэхээр энэ хууль үйлчлэх үү, яах вэ, яаж зохицуулах вэ? Улсын Их Хурал улсын төсвөө батлах хугацааг нь тавьж өгөхгүй бол ингээд нээгээд өгчихөөр хойшоо эрсдэлүүд үүсэх юм биш үү гэсэн. Тэгээд энэ дээр Байнгын хороон дээр яригдчихсан уу, яаж шийдэхээр болсон? Тэгээд ийм бүрхэг ийм байдлаар ингээд хаячих юм уу гэсэн ийм асуулт байна. Тэгээд олон иргэдийн хурлууд өнөө, маргааш хуралдах гээд ингээд та бидний шийдвэрийг хараад байж байгаа. Тэгээд энэ дээр нэг тодорхой хариулт өгөөдхөөч.

Д.Амарбаясгалан: Энэ Даваасүрэн дарга хариулна. Тэгэхдээ энэ хууль маань Наранбаатар гишүүн, нэг удаагийн хууль биш байгаа. Энэ хуульд орсон өөрчлөлт цаашдаа байнга дагаж мөрдөгдөнө. Төсвийн жил гэдэг ойлголт дандаа 01 сарын 01-нээс эхэлдэг. Тэгэхээр бид хуулиараа жил болгон төсвийн хэлэлцүүлгийг он дамнаж хэлэлцдэг, он гаргадаг нөхцөл байдал руу оруулж болохгүй гэдэг нь зарчмын асуудал.

Тийм учраас өнөөдөр бид өөрсдийн асуудлыг орон нутаг руу аваачиж өгч болохгүй учраас Улсын Их Хурал энэ төсөв хэлэлцэх процесс, нөхцөл дээрээ хариуцлагатай хандах ёстой л гэсэн үг. Үнэхээр хариуцлагагүй хандаж чадахгүй бол хариуцлагатай хандаж чадахгүй бол дараа дараачийн өөрчлөлтийг дахиж ярих ёстой болов уу гэж ингэж бодож байна.

Даваасүрэн гишүүн энэ дээр тодорхой хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Тийм, тийм. Ер нь даргын зөвлөл, Байнгын хороо бүх шатад таны ярьсан энэ асуудал хөндөгдсөн байгаа. Засаг захиргаа орон нутгийн нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 36-д төсвөө баталж чадахгүй бол аймаг, сум иргэдийн хурал нь тарна гэсэн ийм заалттай. Тэгэхээр ер нь Их Хурал ч бай, бүх шатын ИТХ иргэдийн өмнө ондоо багцаар төсвөө батлах хариуцлага л хүлээж байгаа. Тийм учраас үүнээс ямар ч зугтах арга байхгүй болчихоод байгаа учраас, энэ хууль цаашдаа бас мөрдөгдөөд явах учраас бид нар онд нь багтаахаас өөр аргагүй нөхцөл байдал үүссэн гэж ингэж үзээд 12 сарын 12 гэхэд Их Хурал үндсэн үүргээ гүйцэтгэж, энэ төсвөө баталж өгөх ёстой.

Тэгээд 20-ны дотор аймгийн ИТХ батална. Тэгээд ондоо багтаагаад сумд багтална гэсэн ийм шахуу графикаар ажиллах нь зүйтэй юм байна. Жилийн төсөв оныхоо эхэнд эхлэх шаардлагатай гэж ингэж үзсэн байгаа. Энэ асуудлыг нэлээн ярьсан.

Д.Амарбаясгалан: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжиж байгаа. Тэгээд яах вэ, энэ өнгөрсөн 32 жилийн хугацаанд анх удаа Ерөнхийлөгч хориг тавьж, Улсын Их Хурал бүрэн энэ хоригийг нь хүлээж авсан байгаа. Тэгэхээр энэ бас бид нарт засаж, сайжруулах зүйлүүд байгаа бол энэ байнгын пар ажиллагаатай парламентын бас давуу талын онцлог гарч энэ өөрчлөлтүүдээ хийхээр ажиллаж байна.

Тэгэхээр энэ хоригийг хүлээж авсан нь зөвхөн цөөн хэдэн гишүүдийн асуудал биш, энэ хамтын шийдвэр учраас энэ сайжруулах зүйлүүдээ ингээд цаашаа засаад явж байгаа нь бас их зөв жишиг болж байна гэж бодож байна. Түүнээс гадна олон

нийтийн хэлэлцүүлгийн асуудлууд бас өмнө нь байнга яригддаг байсан. Тэгэхээр энэ жилийн төсвийн хувьд олон нийтийн хэлэлцүүлэг маш өргөн болж, энэ чиглэл дээр бас ахиц гарсан гэж бодож байна. Ерөнхийлөгч маань хүртэл идэвхтэй оролцлоо.

Тэгэхээр энэ төсөв хуулийн төслүүдийг бас олон нийтийн оролцоо бас их чухал байдаг юм байна гэдэг нь бас энэ хэлэлцүүлгүүдээс харагдсан гэж бодож байна. Тэгээд дээр нь энэ Төсвийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бас Засгийн газрыг бас нэлээн хариуцлагажуулах ийм заалтууд орж ирж байна гэж харагдаж байна. Өмнө нь бас тодорхой хугацаа тавиад, түүнээс цааш бас боломжгүй юм шиг ийм хуулийн заалт байсан бол дахиж өөрчлөх ийм бололцоо боломжуудыг нээж өгч байна.

Тэгээд энэ хуулийн төсөл дээр яах вэ, мэргэжлийн Байнгын хороод дээрээ асуудлуудаа яриад сайжруулах зүйлүүд бас байгаа харагдсан. Тэгээд тэрийг Байнгын хороод дээрээ бас яриад шийдээд ярилцаад явах нь зүйтэй байх гэж бодож байна. Тухайлбал 32-ын штрих 1 дээр улсын нэгдсэн төсөв биш улсын төсөв, тэгээд сангуудын тухай асуудал яригдаад аймаг, нийслэлийн төсөв нь тусдаа юм шиг энэ хуульд хамаарагдахгүй юм шиг ийм ойлголт байгаа. Тэгэхээр энийгээ давхар утгагүй болгох талаар бас Байнгын хороо дээрээ ярих нь зөв байх гэж бодож байна.

2 дугаарт нь, 32-ын штрих 3 дээр бас нэгдсэн төсвийн нийт зарлага болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх гээд. Зарим тохиолдолд энэ чинь нэг удаагийн хууль биш хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа учраас заавал бас алдагдлын хэмжээг нэмэгдүүлэх юу, алдагдлын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх гэдэг заалт бас оруулах шаардлага байна уу, үгүй юү гэдгийг бас Байнгын хороо дээр ярина байх гэж бодож байна. Зарим улсуудын хувьд жишээлбэл хориг тавигдсан үндэслэлүүд нь зарим төсвийн заалтуудаа, зардлууддаа нэмэх чиглэлийн жишээлбэл хоригууд тавигддаг тохиолдлууд бас байдаг юм байна лээ.

Тэгэхээр амьдрал баян учраас, өөр тохиолдлууд гарч ирж магадгүй учраас ингэж хязгаарлах нь бас зарим боломжуудыг хааж магадгүй байх гэж бодож байна.

Дараа нь сая бас яригдаж байна. 32-ын штрих 5 дээр төсвийн жил эхлэхээс өмнө гэдэг энэ бас ойлголтоо Төсвийн байнгын хороо дээр, мэргэжлийн Байнгын хороод дээр сайн ярилцах нь зөв байх гэж бодож байна. Тэгэхээр энэ Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бүхэлд нь дэмжиж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Санал хэллээ. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар: Төсвийн тухай хууль орж ирж байна. Үзэл баримтлалын хувьд хэлэлцэх эсэх яригдаж байгаа учраас үзэл баримтлалын хувьд нэг хэдэн асуулт асууя.

1 дүгээрт, яах вэ, Улсын Их Хурлын төсөв 25 оны төсөв ид ярьж байхад ер нь яг батлах үед 2 гишүүн эсэргүүцэж гар өргөсөн, түүний нэг нь би байна. Тэгээд маш олон гишүүд чухал чухал саналууд гаргаж байсан, тэр үед. Ерөнхийлөгчийн институцээс орж ирж байгаа саналд нэг ялгарах юм алга. Адилхан л зардлаа хэтрүүлж болохгүй, зарим зүйл дээр дутуу байгаа. Цахилгаан, дулааныг 64 хувь

хүртэл нэмэхээр боллоо. Ард иргэд энийг дийлэх юм уу, үгүй юү. Энэ олон асуудлууд бас хаягдсан.

Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл маш чухал мэдээлэл, бас маш чухал дүгнэлт гаргаж өгсөн. Тэгээд зарим гишүүд болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гаргасан дүгнэлтүүдтэй ижил төстэй зүйл Ерөнхийлөгчийн хоригт орж ирж байхад ялгаварлалтай ханддаг энэ Засгийн газрын энэ байдлыг энэ эрх зүйн орчин дээр засаж гаргасан уу? Уучлалт гуйж байгаа юм биш. Зүгээр ер нь үүний ялгаа байдаг юм уу. Тэгээд л хориг хүлээж байгаад л хоригийг хүлээж авна. Гишүүд ярих, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл яг шинжлэх ухааны үндэслэлтэй асуудлыг гаргаж тавих 2-т яагаад ийм ялгаатай хандаж байгаа юм бэ? Эрх зүйн дүгнэлт гаргасан уу? 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт. Би олон зүйл дээр төсөв дээр эсрэг байж, засаж залруулах гэж оролдсон. Хэлэлцэх эсэх эхний хэлэлцүүлэг дээр ярьсан. 2 дахь, 3 дахь дээр би ярихаа больсон. Ярих ч үндэс байхгүй. Одоо харин надад ярих боломж олдож байна. Тэгэхээр Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсан, авахаас өөр арга байхгүй. Нийгэм ийм хүлээж авахааргүй хэцүү байдалтай байна.

Миний асуулт. Хэлэлцүүлгийн шатад энэ төсөв чинь 70 гаруй хоног хэлэлцэж байгаа шүү дээ. Хэлэлцүүлгийн шатад Ерөнхийлөгчийн зүгээс энэ төсөв хариуцсан хүн байдаг бол яагаад ган гэж ганц удаа дуугараагүй юм бэ. Яагаад яг энэ хэлэлцүүлж байгаа 70 гаруй хоног дээр чив чимээгүй алгаа үрж байж байгаад, 4 удаа хэлэлцсэний дараа гэнэт босож ирээд хориг тавьж болдог юм уу? Энэ дээр, энэ цэвэр би эрх зүйн асуулт асууж байгаа юм шүү. Энэ дээр та бүхэн хоорондоо хэлэлцээд зөвлөлдсөн үү? Энэ чинь ганцхан давхар шүү дээ. Нэг нь 3 давхарт байдаг, нөгөө Сангийн сайд 4 давхарт байгаа. Энэ 2-ын хооронд хэдхэн алхмын зайтай, уулзах боломжууд байсан уу? Заавал ч үгүй 11 сарын 20-ноос улс орон даяараа ингэж үүсрэх шаардлага байсан уу? Энэ чинь Үндсэн хуульд байгаа 33.2-т байна уу, эрх мэдлийг салаа, нэг салаа руугаа дамнаж орж ирж, хориг тавихыг хүндэтгэлтэй бас хандах тийм зүйл заалтууд бас байдаг. Хоорондоо мэдээллээ солилцож, Засгийн газарт бол чиглэл өгч байгаа, Улсын Их Хуралд бол хориг тавьж байгаа. Зөвлөлдөх тэр механизмууд нь энэ хууль, эрх зүйн шинээр гарч ирж байгаа энэ төсвийн тухай хууль дээр одоо би хэлэлцэх эсэх буюу үзэл баримтлалын хувьд ярьж байгаа учраас дараа нь ярих боломж олдохгүй байх. Ярилцсан уу, ойлголцсон уу?

Миний асууж байсан, төсвийн хувьд асууж байсан 3 дахь асуулт. Төсвийн үед эсрэг байсан зардал алдагдалтай байна гэж. Төсвийн зардал алдагдалтай байна гэдэг бол нэргүй татвар гэж байгаа юм шүү дээ. Сүүлд нь ААН-үүд, үйлдвэрлэгчид, Монголын жирийн хөдөлмөр хийж байгаа ард иргэд хүүтэй буцаж төлдөг. Бүр татвараас илүү гадаадын хүүтэй төлдөг. Тэгэхээр энэ дээр би энэ Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг ярьж байгаа шүү. Тэгэхээр энэ миний ярьж байгаа зүйлүүдтэй холбогдуулж, эрх зүйн орчин дээр нь дүн шинжилгээ хийсэн үү гэсэн 3 асуултдаа би хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн хариулъя.

Ц.Даваасүрэн: Ганбаатар гишүүн 25 оны төсвийн тухай хууль биш байхгүй юу. Өнөөдрийн хуулийн асуудал бол юу, зүгээр төсвийн ерөнхий хууль дээр, төсвийн ерөнхий хууль дээр энэ тодорхойгүй, зохицуулагдаагүй нөхцөл байдал

үүссэн учраас төсвийг буцаавал, буцаагаад орж ирэхэд яаж хэлэлцэх юм бэ гэдэг л тийм дэгийг л Төсвийн хуульд оруулж өгч байгаа юм. Түүнээс биш нөгөө төсөвтэй холбоотой асуудал бол би 3 дахь өдөр өргөгдөх юм байна гэж ингэж ойлгосон.

Тийм учраас та 25 оны төсвийн тухай хууль өргөдөнгүүт энэ асуултуудаа асуувал арай юу байх.

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя.

С.Ганбаатар: Тийм ээ, би ойлгож байгаа. Даваасүрэн гишүүний саналтай бас санал нэг байна аа. Тэгээд энэ Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал гэдэг дотор Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 гээд ингээд 2024 оны 11 сарын 20-ны өдөр ингээд бүхэлд нь хориг тавьснаас улбаалж, хоригийг хэлэлцэгч хүлээж авсан. Энэтэй холбогдуулж өнөөдөр бид энэ хуулийн өөрчлөлтийг оруулж ирж байгаа. Тэгээд энэ тал дээр эрх зүйн дүн шинжилгээ миний асуусан 3 зүйл дээр байгаа юу? Сангийн яамны яг бодлого, асуудал хариуцсан улсууд нь хариулах болов уу гэж би бодож найдаж байсан. Ийм утгатай би асуулт асуусан шүү.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр өнөөдөр Төсвийн тухай хуулийн нэмэлт орж байгаатай холбоотой асуудал яригдаж байгаа учраас Ганбаатар гишүүний энэ асуудлыг төсөв өргөн баригдах үед нь хариулт өгөх нь зөв байх гэж бодож байна. Яагаад гэвэл бид бас дэгийн хуулийн дагуу хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуудлаар асуулт асууж, хариулт авах дэгийн хуультай учраас.

Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя. Жигжидийн Батжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ өглөөний амар амгаланг айлтгая. Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжиж байгаа юм аа. Дэмжих бас учир шалтгаан байгаад байна. Үүсчихсэн шинэ нөхцөл байдалтай уялдуулаад төсвийг дахин өргөн мэдүүлэх эрх зүйн харилцаа зохицуулагдаагүй.

Тийм учраас бид Төсвийн тухай хуульдаа нэмэлт оруулж, энэ харилцааг зохицуулах зайлшгүй нөхцөл байдал үүссэн. Үүнтэй уялдагдаж энэ хууль боловсрогдлоо гэж ингэж би ойлгож байгаа. Гэхдээ энэ төсөв бол бүхий л цаг хугацааныхаа цаглавраар боловсрогдож орж ирсэн төсөв дээр тодорхой тодотгол өөрчлөлтүүд хийгдэж орж ирж байгаа учраас арай хялбаршуулсан байдлаар өргөн мэдүүлж, хэлэлцэх үйл явц байж болох тухай асуудлыг энэ хуулиар би зохицуулж байгаа юм байна гэж ингэж ойлголоо. Үүгээрээ дамжиж харин энэ жил бол бид бас нэг тийм шинэ нөхцөл байдлыг бий болгож чадав уу гэж хараад байгаа юм. Төсвийнхөө талаар төрийн эрх барьж байгаа байгууллага нь ч тэр, гүйцэтгэх засаглалын байгууллага нь ч тэр, иргэд олон түмэн нь ч тэр бүгд анхаарлаа төвлөрүүлж, ер нь энэ улс орны төсвийн бүтэц, тэгээд төсөв үр ашигтай байх тал дээр нийтээрээ нэлээн анхаарал төвлөрүүлсэн ийм он жил болж байна. Үүн дээрээ тулгуурлаж цаашид энэ төсвийн шинэчлэлийн асуудал дээр томоохон эхлэл үүсэх байх гэж би бол ингэж харж байгаа. Тийм учраас энэ Төсвийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг бүрэн дэмжье ээ.

Харин хэлэлцүүлгийн түвшинд анхаармаар зүйл бий. Дан дамаа энэ нэмэлт, өөрчлөлтийн тэр Улсын Их Хурал аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ төсөв батлах

тэр үйл явцыг цаг хугацааны тодорхой цаглавартай болгож, 3 шатдаа тодорхой хугацаагаар бас хариуцлагажиж, илүү шахаж ажиллах ийм шаардлага гарах юм байна. Үүнийг ажлын хэсэг, Төсвийн байнгын хороо дээр илүү анхаарч ажиллах ёстой байх аа. Би төсөл өргөн баригчийг энэ талаар ер нь ерөнхий төсөөлөл байр суурь нь ямархуу байна вэ гэдэг талаар тодруулъя. Тэгээд энд төслийг дэмжиж байна. Бид энэ хуулийг баталснаараа төсвөө дахин өргөн мэдүүлж, шуурхай хэлэлцэж, энэ улс орны ирэх он жилийн төсвийн зохицуулалтыг хангаж өгөх ийм бололцоо боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн хариулъя.

Ц.Даваасүрэн: Тийм, Батжаргал гишүүний болгоомжлоод байгаа асуудлыг бид нар бас Байнгын хороо дээр нэлээн ярилцсан. Ялангуяа хугацаандаа багтаж батлах асуудал. Энэ нөхцөл байдал маань хамгийн хүндрэлтэй цаашдаа өргөжиж болзошгүй юм бол тэр Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 36-аар сумд, аймгийн иргэдийн хурал тарах нөхцөл үүсгэж болзошгүй болчхоод байгаа юм. Хэрвээ ондоо багтахгүй бол. Тийм учраас бид нар энэ цаг хугацааны асуудал дээр хэлэлцүүлгийн дэг дээр бас анхаарах юмнууд бий. Дэгээрээ төсвийн хэлэлцүүлгүүд 5 хоногийн зайтай явдаг. Үүнийг хугацааг нь богиносгох ийм шаардлага нөхцөл байдал үүсэж байгаа.

Тийм учраас үүнийг нэг удаагийн хуулиараа бид нар зохицуулаад ингээд маш яаралтай горимоор ингэж хэлэлцэхээс аргагүй ийм нөхцөл байдал үүссэн байгаа. Бид нар 12 гэхэд батлахгүй бол нөгөө аймгийн иргэдийн хурал, сумдын иргэдийн хуралд төсвөө батлах хугацаа байхгүй болчих гээд байгаа юм гэдгийг л бид нар анхаарах ёстой. Энэ нөхцөл байдал маань орон нутагт нөлөөлөх юм бол маш хүндрэлтэй ийм нөхцөл байдлыг үүсгэхээр байгаад байгаа юм аа.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Гишүүдэд өглөөний мэнд хүргэе. Төсвийг дахин өргөн барих харилцааг зохицуулах шаардлагатай тулгарч байна л даа. Тэгэхээр энэ дахин өргөн барих гэдэгт өргөн барих үндэст нь нэг 2 зүйл давхцаад байх шиг харагдаад байгаа юм.

1 дүгээрт нь, Ерөнхийлөгч төсөвт бүхэлд нь хориг тавиад Улсын Их Хурал хүлээж авсан. Энэ нь өөрөө энэ төсвийг бараг ингээд үйлчлэлгүй болгочхож байгаа. Энийг нэмээд Улсын Их Хурлаас 25 оны төсвийг хүчингүй болгочихсон. Тэгэхээр Ерөнхийлөгч бүхэлд нь хориг тавиад хоригийг хүлээж авах гэдэг өөрөө нэг эрх зүйн баримт бичиг.

Нөгөө талд нь нэмээд хүчингүй болгочихсон. Тэгэхээр эндээс төсвөө өргөн барих яг шалтгаан нь аль нь болж байна вэ. Хоригийг, Ерөнхийлөгч бүхэлд нь хориг тавиад хоригийг 3-ны 1-ээр хүлээгээд авчихсан уу, аль эсвэл Улсын Их Хурлын 2-ны 1-ээр төсвийг хүчингүй болгочихсон нь дахин өргөн барих аль шалтгаан нь юм бэ? 1 дүгээрт нь.

2 дугаарт нь, хэрэвзээ Ерөнхийлөгчийн хоригийг ер нь дараа дараагийн жилүүдэд бүхэлд нь тавьсан хоригийг 3-ны 1-ээр хүлээж аваад, 2-ны 1-ээр хэрвээ төсвийн хуулийг хүчингүй болгохгүй бол яах юм. Дахин өргөн барих харилцаа үүсэхүү гэх зэргийн асуултууд яг энэ болж байгаа үйл явдлуудаас ингээд харагдаад

байна л даа. Тэгэхээр энэ дээр энэ нөхцөл байдлуудыг яаж, хууль санаачлагчид хууль өргөн барьж байгаа Засгийн газрын зүгээс яаж харсан бэ гэдэг дээр нэг тайлбар өгөөч. Хэрвээ ийм нөхцөл үүсвэл яах юм.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хороон дарга Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн хариулъя.

Ц.Даваасүрэн: Хоригийг хүлээж авсан тохиолдолд хоёрхон сонголт байгаад байгаа юм. Нэг бол хүчингүй болгох, нөгөөдөх нь нэмэлт өөрчлөлт оруулаад явах. Төсвийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна гэдэг бол тодотгол учраас тодотголын хэмжээ, Байнгын хороо нь хууль санаачлаад явна гэж байгаа байхгүй юу. Нэмэлт өөрчлөлт оруулах хуулийг. Тэгэхээр тийм, үгүй хэрвээ, хоёрхон л тохиолдол байгаа байхгүй юу. Нэг бол хүчингүй болгоно, нэг бол нэмэлт, өөрчлөлт хийнэ. Тэгэхээр төсвийн нэмэлт, өөрчлөлт гэдэг чинь тодотгол. Тэгэхээр тодотголын хэмжээний ийм өөрчлөлтийг Байнгын хороо хариуцаад хийнэ гэдэг хүндрэлтэй.

Хэрвээ бид нар хоригийг хүлээж аваагүй бол төсвийн хууль хүчин төгөлдөр болоод л явчихна. Хоригийг хүлээж аваад хүчингүй болгочхож байгаа учраас шинээр төсөв өргөхөөс өөр аргагүй. Яагаад гэвэл тэр төсвийн хууль хүчингүй болчхож байгаа юм. Бид нар баталсан хууль. Бидний одоо хүлээж аваад хүчингүй болгосон нь энэ шинээр төсөв өргөн барих нөхцөл байдлыг үүсгэсэн гэж таны асуултад ингэж л хариулах байна. Хүчингүй болгохгүй бол төсвийн хууль хүчин төгөлдөр болоод л явчихна. Тэгээд хоригийг хүлээж авахгүй байх юм бол Төсвийн хууль үйлчлээд л явчих байсан байхгүй юу.

Д.Амарбаясгалан: Биш ээ. Хоригийг хүлээж авчхаад, хүлээж авчхаад хуулиа хүчингүй болгохгүй бол яах вэ гэж асууж байна шүү дээ.

Ц.Даваасүрэн: Тэр чинь нэмэлт, өөрчлөлт шүү дээ. Тэр чинь нэмэлт, өөрчлөлт байхгүй юу. Тэгэхээр нэмэлт, өөрчлөлт хийнэ гэдэг чинь төсвийн тодотгол болчхоод байгаа юм. Тэгэхээр төсвийн тодотголыг боловсруулж, төлөвлөж оруулж ирэх эрх үүрэг нь Засгийн газарт байгаад байгаа юм. Тэгээд тэр 90.9 дээрээ, 9 дээр ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ингэчихье. Энэ дээр их тодорхой хариулчихъя.

1 дүгээрт, Ерөнхийлөгчийн хориг бүхлээрээ тавигдчихсан. Бүхлээр нь тавьсан хоригт төсвийн алдагдлыг алдагдалгүй болгох гэсэн өгүүлбэр ороод ирчихсэн. Алдагдалгүй болгохын тулд хаанаас ямар хэмжээний төсвийн таналт хийх вэ гэдэг асуудал бол яг мэргэжлийн яамны хариуцаж хийх ёстой асуудал болсон учраас Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, ХЗБХ хамтарсан хурлаа хийгээд, төсвийн хууль буюу 25 оны батлагдсан төсвийг хүчингүй болгоод, дахиж өргөн барих энэ тогтоолыг баталчихсан.

Тэгээд өргөн барих процесс нь өөрөө энэ төсвийн тухай хуульдаа байхгүй байгаа учраас өнөөдөр тэрийг нь нээж, өгөх илүү хялбаршуулсан хэлбэрээр өргөн барих боломж бололцоог нь нээж өгч байгаа юм. Төсөв өөрөө алдагдалгүй батлагдана гэдэг талаар өчигдөр бас манай улс төрийн намын бүлгүүд, улс төрчид байр сууриа илэрхийлсэн байна лээ. 1,9 их наядаас 2,4 их наядын хооронд төсөв танагдах нөхцөл рүү орлоо гэдэг асуудал яригдаж байгаа. Тэгээд энэ дундаа хэрхэн яаж таналт хийх талаар Засгийн газар шинээр өргөн барих төсөвтөө бодлогоо тусгаж оруулж ирнэ.

Харин өнөөдөр Засгийн газрын санаачилгаар өргөн барихаасаа өмнө улс төрийн намын бүлгүүдэд зарчмаа танилцуулна гэдэг ийм байр суурийг илэрхийлж байгаа. Яагаад гэвэл энд маш олон төрийн албан хаагчдын болон бусад түвшин дээр асуудлууд хөндөгдөх учраас энэ асуудалд зарчмаа Засгийн газар урьдчилж намын бүлгүүдэд танилцуулсны үндсэн дээр өргөн барих процессоо явуулна гэсэн ийм байр суурьтай байгаа.

Болдын Жавхлан сайд энэ дээр нэмэлт тайлбар хийе.

Б.Жавхлан: Сая та бараг хэлчихлээ дээ, санаа давхардчихлаа. Ер нь яах вэ, Цогтгэрэл гишүүний асуулт, би ингэж ойлгосон шүү. Ерөнхийлөгчийн хориг нь юм уу, эсвэл хүчингүй болгосон нь юм уу гээд. Тэгэхээр миний харж байгаагаар энэ үргэлжилж байгаа процесс. Ерөнхийлөгчийн хоригийг Их Хурал хүлээж авсан. Сая яг Их Хурлын даргын хэлсэнчлэн төлөвлөх шатдаа энэ чинь бас нэлээн адармаатай. Энэ чинь нэлээн тооцоолол, суух ажлууд байгаа учраас Засгийн газар өөрсдөө хийх нь зөв өө гээд хуулийг хүчингүй болгоод, Засгийн газрын түвшинд төлөвлөлтөө хийгээд ир гээд ингээд явуулсан. Харин төлөвлөлтөө хийгээд оруулаад ирэх энэ процессыг нь тэгвэл арай хялбаршуулаад хэдүүлээ тэр оруулаад ирсэн юмыг нь богинохон хугацаанд хэлэлцээд явъя гэдэг ийм процессоор явж байна гэж харж байгаа.

Харин 2 дахь асуулт хориг хүлээж аваад одоо бүхэлд нь юм уу, цаашдаа хэсэгчилж ч юм уу Их Хурал дээр нэг засах хэмжээний тийм зүйлүүд болчихоор зүйлүүд байвал ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тийм, хэсэгчилсэн хэлбэрээр юм уу, Их Хурлын түвшинд хийх боломжтой зүйл бол Их Хурал Байнгын хороогоороо дамжуулаад, ажлын хэсгээр дамжуулаад хийчих бүрэн боломжтой. Энэ удаагийн танах үйл ажиллагаа чинь зөвхөн юу гэдэг юм, урсгал зардлыг бууруулаад болчих хэмжээний асуудал биш болж байгаа учраас Засгийн газар, Сангийн яам, бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсөвт хэмнэлт хийх, тодорхой төрлийн хөрөнгө оруулалтыг багасгах, тэгээд олон асуудал дээр энд асуудал хөндөгдөж байгаа юм байна лээ.

Гэхдээ өнөөдөр бид эхлээд энэ төсвөө эргэн өргөн барих нөхцөлийг нь бүрдүүлж өгсний ард дээр төсөв шинээр өргөн барих процесс эхэлнэ. Тэр өргөн барих процесс эхлэх үед Засгийн газар, Сангийн яамны санал бол улс төрийн намын бүлгүүдэд бодит нөхцөл байдлыг танилцуулж, зарчмаа тогтсоны үндсэн дээр өргөн барья гэдэг ийм байр суурьтай байгаа. Тэгэхгүй бол одоо бас Улсын Их Хурлын гишүүд маань зарим талаар дутуу мэдээлэлтэй, дутуу мэдээлэлтэй байгаагаасаа болоод буруу, зөрүү мэдээллийг олон нийтэд хүргэж, уур бухимдлыг нь хүргэдэг, эргээд ажлаа явуулж чадахгүй хэмжээ рүү ордог ийм тохиолдол бас мэр сэр гарч байна аа. Тийм учраас гишүүд маань маш ул суурьтай хандах ёстой шүү.

Сая хэрвээ Улсын Их Хурлын түвшинд энэ 1,9-2,4 их наядын хэмжээнд, магадгүй гишүүдийн тавьсан шаардлагаар 3,6 их наядар урсгал зардлыг бууруулах хэмжээний асуудлыг Их Хурал авч хийж чадахаар шийдвэр гарсан бол Их Хурал чадахгүй хэмжээнд хүрэх байсан гэдгийг бид дор бүрнээ ойлгох ёстой. Их Хурлын Байнгын хороо болон ажлын хэсгийн түвшинд тийм потенциал байхгүй. Мэргэжлийн яамны түвшинд байгаа тооцоо, судалгаа бүрэн байхгүй. Түүнээсээ болоод энэ хаус хэлбэр лүү орж, Их Хурал төсвөө баталж чадахгүй хэмжээ рүү явах аюул бас байсан гэдгийг аль аль талаасаа бас бодолцох ёстой. Тэр ч утгаараа яаравчилсан

түргэвчилсэн горимоор энэ төсвийг баталж өгөх ёстой. Энэ Улсын Их Хурал дээр төсөв батлагдах үйл ажиллагаа, процесс, удаашрал үүсэж байгаа нь цаашлаад орон нутгийн түвшинд халдварлаж болохгүй гэсэн бас ийм байр суурьтай байгаа. Тэр ч утгаараа өнөөдөр энэ хуулийн төсөл дээр ондоо багтааж, хуулиа батлах энэ хатуу заалт орж ирж байгаа.

Тэгэхээр Улсын Их Хурал, Засгийн газар, орон нутгийн түвшинд бүх тал дээрээ энэ дээр анхаарч ажиллана гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуулт асууя.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн ерөнхий үзэл баримтлалыг дэмжиж байгаа. Бид 2025 оны төсөв хэлэлцэх энэ хэлэлцүүлэг өмнөх онуудын төсөв хэлэлцэж байснаас эрс ялгаатай. Олон нийтийн хэлэлцүүлэг, ард иргэдийн, парламентын гишүүдийн, засаг төрийн бүхий л түвшинд нэлээн урт хугацааны хэлэлцүүлгүүд явлаа. Тэгээд яагаад өнөөдрийн түвшинд хүрчхэв гэдгээ бид бас анхаарах ёстой гэж бодож байгаа юм. Зүгээр энэ үүсээд байгаа нөхцөл байдлыг харахаар бид бас Их Хурлын танхимд сууж байгаа ард иргэдээ төлөөлөөд гараад ирсэн Улсын Их Хурлын гишүүд бол дэгийн хуулийн хүрээнд хэзээ, яаж, төсөв буцаах вэ, хэзээ, яаж, төсөвт ямар асуудлууд оруулах вэ гэдэг дээр бас хариуцлагатай хандаж байхгүй бол ийм нөхцөл байдалд бид нар олон удаа хүрэх магадлалтай юм байна гэдгийг л харууллаа гэж харж байгаа юм. 126 гишүүн шинэ тогтолцоогоор сонгогдсон. Яг үнэндээ энд бас шийдвэр гаргах түвшинд үнэхээр энэ төсөвтэй холбоотой асуудлууд дээр хасах гээд байгаа тэр тооныхоо ард юу байсан бэ, юуг нь хасах ёстой юм бэ гэдгээ хэлж чадах хүн цөөхөн байгаа.

Тэгэхээр бид бас асуудал гаргаж байгаа юмандаа нэлээн зарчимтай, бодолтой, тооцоо судалгаатай байж байж асуудлаа ярихгүй бол үндсэн процессынхоо асуудлыг ингэж чагтлаад зогсоочихдог ийм жишгийг бас тогтоож болохгүй л гэж харж байгаа. Улсын Их Хурлын хувьд яг гаргасан шийдвэр ямар нэгэн байдлаар хууль зөрчсөн шийдвэр гаргасан гэж би бол үзэхгүй байгаа. Үнэхээр энэ төсвийг зарчмын хэмжээний ийм том өөрчлөлт оруулахад ялангуяа Ерөнхийлөгчийн хориг бүхэлд нь хориг тавьчихсан байгаа энэ үед бол Их Хурал ажиллахаас илүү Засгийн газар ажиллаж, төсвөө нягталж, дахиж оруулж ирэх нь зүйтэй байсан учраас энэ хамгийн зөв хувилбар байсан л гэж харж байгаа.

Одоо харин яг энэ процессын явцад хуулиар зохицуулаагүй олон асуудлууд бидэнд бас байна шүү гэдгийг гаргаж ирсэн нэг давуу тал байлаа. Үүний хүрээнд ч өнөөдөр төсвийн тухай хууль дээр энэ нэмэлтээр байнга мөрдөгдөх ийм зохицуулалтууд орж ирж байгааг дэмжиж байгаа. Харин энэ хуулийн хамгийн сүүлийн заалт байгаа шүү дээ. Энэ төсвийг бид нар ондоо багтааж, аймаг ч тэр, аймгийн иргэдийн хурал ч тэр, Улсын Их Хурал ч тэр батлах ёстой гэж. Дэгийн тухай хуулиараа явах юм бол бид нар энэ хугацаанд багтаахааргүй байгаа.

Тэгэхээр энэ дээр ямар өөрчлөлтүүдийг оруулах вэ? Засгийн газар мэдээж дэгийн хуульд өөрчлөлт санаачлах эрхгүй учраас орж ирээгүй байх. Байнгын хороо энэ дээр ямар бодлого барьж байгаа вэ? Цаашдаа энийг ямар дэгээр бид нар хэлэлцэх ёстой юм. 5, 5 хоногоор нь явах ёстой юм уу. Ямар процессуудыг нь алгасаж байж энэ хугацаандаа амжих ёстой юм бол. Энэ нөхцөл байдлыг бас тодруулах нь зүйтэй болов уу гэж бодогдож байна.

Тэгээд зарчмын зөрөөтэй саналуудаа анхны хэлэлцүүлэг дээр бас гаргаад явна. Мэдээж энэ хуультай яг хэлэлцэх үед нь бас ярих асуудлууд байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга байна уу? Баярбаатар гишүүн. Энэ чуулгандаа ирдэггүй гишүүдийг хариуцлага тооцно гэж байгаа шүү дээ. Чуулгандаа тогтмол ирж суудаг гишүүдийг урамшуулна гэхээр хүмүүс мөнгөн урамшуулал гэж бодоод байх шиг байгаа юм. Мөнгөн урамшуулал биш, чуулгандаа тогтмол ирж суудаг гишүүдийг ер нь урагшаагаа суудаг байх тэр боломжийг нь нээж өгөх нь зүйтэй гэж бодож байгаа юм. Урдуур суучхаад хамаг суудлууд хоосон суугаад байдаг энэ байдлыг ч гэсэн засаад ер нь оролцоог нь илүү хангах замаар гишүүдийнхээ урамшууллийг өгье өө гэж ингэж бодож байгаа юм.

Энэ Үүрийнтуяа гишүүний асуултад хариулах хүн байна уу? Ёс зүйн дэгийн байнгын хороо, Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн гишүүн хариулъя.

Ц.Даваасүрэн: Тийм, Үүрийнтуяа гишүүн маш зөв харсан байна. Ер нь ингээд төсвийг бид нар өсөхөөс нь өмнө зогсоох ёстой байхгүй юу. Нэмэгдүүлэхгүй байхад нь эхэлж анхаарах ёстой. Төсөв нэгэнт нэмэгдээд ингээд өсөөд явчихаар бүх зардал эзэнтэй болчихож байгаа юм. Нэг бол цалин болчихсон байгаа, нэг бол нэг байгууллагын санхүүжилт болчихсон байгаа. Яг тэгээд хасахад маш их хүндрэл гарна. Одоо зүгээр яг энэ төсвөө хэлэлцээд эхлэхээр энэ харагдах байх гэж би бодож байна.

Таны хэлээд байгаа шинэ нөхцөл байдал үүссэн үү гэвэл үүссэн. Бид нар чинь үндсэндээ 30-аад жилийн 30 гаруй жилийн хугацаанд байхгүй тохиолдоогүй нөхцөл байдлыг бий болгочоод сууж байна шүү дээ. Тэгээд орон нутгийн иргэдийн хурал нь тарах нөхцөл байдал үүсчихсэн бараг, хэрвээ бид нар хугацаандаа баталж чадахгүй юм бол. Ингээд энэ маань Их Хурлын асуудал маань цаашдаа орон нутгийн ИТХ-ын асуудал болоод хувирчихсан ингээд сууж байгаа байхгүй юу. Улс орны хувь заяаны асуудал. Тийм учраас бид нар энэ дээр нэлээн, нэлээн бодох ёстой юмнууд бидэнд байгаа юм. Ондоо яаж багтаах вэ гэдэг асуудал болчихоод байгаа юм. Тийм учраас таны асуугаад байгаа тэр нөгөө нэг хэлэлцүүлгийг 5 хоногийн зайтай явна гэдэг энэ заалтыг нэг удаагийн хуулиар бид нар дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулаад сая Баярбаатар дарга хариулах ёстой байлаа. Гэтэл тэр дэгийн тухай хуулийн 5 хоногийн хугацааг 1 хоног болгож өөрчилж ингэж хэлэлцэхгүй бол бид нар хугацаандаа хэлэлцэж амжихгүй болчихоод байгаа юм. Тийм учраас дэгийн тухай хуульд 1 удаа үйлчлэх ийм хуулийн өөрчлөлт хийгээд, хэлэлцүүлгээ хийгээд явна гэсэн ийм л төлөвлөгөөтэй байгаа юм.

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхбат: Бүгдээрээ 2025 оныхоо төсвийн тухай хуулийг дахин хэлэлцэхээр болж байна. Тэгээд энэ хуулийн төслөө бүгдээрээ Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьсантай холбогдуулаад бүгдээрээ хэлэлцэхээс өөр аргагүй байдалд үүссэн. Бүгдээрээ л хүлээгээд авчихсан юм чинь дэмжиж байгаа гэж ингэж ойлгоно.

Миний асуух гээд байгаа гол зүйлүүд энэ төсөв хэлэлцэх үед л асуугдах болчих шиг боллоо. Сая энэ Ганбаатар гишүүний асуултаас харахад. Гэхдээ бид нар энэ цаашдаа ер нь яг яаж явах юм бэ гэдгээ энэ хүрээндээ ярих нь зүгээр санагдаж байгаа юм. Энэ Засгийн газар, Засгийн газрын гишүүдийг

хариуцлагажуулах, бас мэдрэмжтэй байх тал дээр нь, бас анхаарахгүй бол яг үнэндээ 36 их наяд төгрөгийн төсөв батлах гэж байгаа. Тэр дунд нь энэ нийгмийн сэтгэл зүйг иргэд, олон нийтийн бухимдлыг төрүүлсэн цөөхөн дүнтэй тийм төсвүүдээс болоод л өнөөдөр ийм байдалд хүрч байгаа шүү дээ. Ер нь болбол. Тэгээд Засгийн газар нь оруулж ирсэн төсвөө хайрцгаасаа гаргахгүй л гээд л тэр чигээр нь зүтгүүлсэн байх бодвол. Уг нь тэр бол нэг 18 тэрбумын ваучер, тэр нэг 20 тэрбумын бяслагийн үйлдвэр. Тэгээд л 1,9 их наяд төгрөгийн бусдаар гүйцэтгүүлэх ажил ойлгомжгүй байна гээд л. Тэгээд энэ зүйлүүд дээрээ л эргээд анхаарчихсан бол тэгээд л уг нь өдийд ийм байдалд хүрэхгүй л явж байх байсан болов уу гээд ингээд бодогдож байгаа.

Тэгээд энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тэр дүгнэлтийг хэр хүлээж авч байгаа вэ? Мэдээж зардал тал дээр нь өөрчлөлтүүд орж таарна. Одоо бид нар төсвөө алдагдалгүй болгоно, алдагдлыг нь бууруулна гэхээр. Орлого тал дээр өөрчлөлт орж байгаа юу гэсэн ийм асуултууд байгаа юм.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье.

Пүрэвдорж гишүүн юу яая, төсөв орж ирэхээр наад асуудлуудаа ярья. Одоо өнөөдөр Төсвийн тухай хуульд орох нэмэлт, өөрчлөлт, нэмэлтийн талаар ярьж байна.

Даваасүрэн гишүүн, Болдын Жавхлан сайд Цагаанхүүгийн Мөнхбат гишүүний асуултад хариулъя.

Б.Жавхлан: Мөнхбат гишүүний асуултад хариулъя. Гишүүн ээ, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн санал, дүгнэлтийг тусгах ёстой юу маань нөгөө 25 оны төсөв шүү дээ. 25 оны төсвийг өргөн бариагүй байгаа. Засгийн газар ч хэлэлцээгүй байгаа. Тийм, энэ удаа тэр төсөв ороод ирвэл тэрийг яаж хэлэлцэх вэ, тэрийг яаж өргөн барих вэ гэдэг хуулиа ярилцаж байгаа учраас одоо таны тэр асуултад хариулах боломжгүй байна. Тийм, Засгийн газраар эцэслээгүй байгаа учраас.

Д.Амарбаясгалан: Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Амьдрал мэдээж баялаг. Тэгэхээр энэ удаагийн энэ төсвийг бүхэлд нь хориг тавиад, засаг руу буцаагаад, ингэж байгаа нь анхны тохиолдол юм байна. Ер нь цаашдаа ийм юм гарч болзошгүй л гэсэн үг байхгүй юу. Тийм болохоор төсвөө баталж чадахгүй бол нэгэнт Төсвийн тухай хууль л ярьж байгаа учраас яах вэ гэдэг дээр анхаарал хандуулмаар байна, цаашдаа. Төсвийн тухай хуулийн дагуу төсвөө баталж чадахгүй байх юм бол дараа жил нь төрийн албан хаагчид хөдөлмөрийн доод хэмжээ 660 мянган төгрөгийн цалин авна, тэтгэвэр тэтгэмж бас хамгийн багаараа байна, ингээд том хямрал болно шүү гээд Жавхлан сайд айлгаад байсан.

Сая Даваасүрэн дарга бас төсвөө баталж чадахгүй бол орон нутгийн иргэдийн хурал тарах эрсдэл үүснэ гээд айлгаад байна. Тэгэхээр энэ өөрөө ийм айдас дээр тулгуурласан биш, төсвийг үр ашигтайгаар хэрхэн зарцуулах вэ гэдгийг л Их Хурал хэлэлцэх ёстой шүү дээ. Тийм болохоор энэ төсвийн хууль дээр байгаа 41.4 дээр хэрвээ хугацаандаа амжихгүй бол төсвийн байгууллагад ажилтны цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр, нийгмийн хангамжийн болон нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийг доод хэмжээгээр гэдгийг дараагийн заалтууд дээр

байгаа шиг өмнөх оны түвшинд гэж өөрчлөх ийм саналыг гаргамаар байна. Энийг энэ Төсвийн байнгын хороо, ажлын хэсэг нэгэнт Төсвийн тухай хууль ярьж байгаа хүрээнд хэлэлцэх боломжтой юу гэж асуумаар байгаа юм.

Нэмээд хэлэхэд энэ төсөв чинь төсвийн цаана эдийн засгийн загвар байгаа. Улс төр байгаа, Монголчууд яаж хөгжих вэ, тэр онцлог нь хүртэл байгаа учраас ингэж удаан хэлэлцэх нь гарцаагүй. Тэртээ тэргүй бас ингээд олон жил яаралтай ингээд батлаад батлаад явчихсан юм шиг иймэрхүү үр дагавар харагдаад байна шүү дээ. Одоо энэ шинэ парламент бүрдсэнээс хойш л эхлээд л түрүүчийн парламент хэлэлцэхгүй хаячихсан 23 оны төсвийг хэлэлцээд, хуульдаа өөрчлөлт оруулж байгаад хэлэлцээд баталсан. Түүн дээр нь аудит их ноцтой дүгнэлт хийчихсэн байсан. Баталчихъя, дараа нь ажлын хэсэг гарч хянана гэсэн. 24 оныхоо төсвийг төсвийн хүрээний мэдэгдэл эхэлж ороод дараа нь төсвөө орох ёстой байдаг, хоёуланг нь зэрэг оруулаад, ямар ч байсан баталъя гээд явчихсан. 25 оны төсөв нь тодотголтой баталъя гээд явсан, дараа нь хориг тавьсан. Тэгэхээр ингээд ер нь болохгүй байгааг л харуулаад байна л даа. Тийм болохоор нэгэнт энэ суурь чанартай Их Хурлын хийх хамгийн гол ажлуудын нэг. Ийм учраас энэ дээр бас сайн сууж ажилладаг энэ боломжийг нь бүрдүүлмээр байна.

Хэрвээ ямар нэгэн байдлаар ямрыг бол бид нар мэдэхгүй. Ямар ч эрсдэл энэ амьдралд бий болж болно. Хугацаандаа амжихгүй бол гарах үр дагавар нь нийгмийг донсгосон хямралын хэмжээнд хүрэхээргүйгээр төсвийн хуульдаа зохицуулалт хиймээр байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Байз, энэ Золжаргал гишүүн. Пүүжээ гишүүн ээ, түр байж байгаарай. Пүрэвдорж гишүүн ээ. Хөөе Пүрэвдорж гишүүн. Сануулах арга хэмжээ авлаа шүү.

Золжаргал гишүүн 09 сарын 01-нээс хойш өнөөдрийг хүртэл төсөв өргөн баригдаад, хэлэлцэгдээд, хориг тавигдаад, буцааж баталсан хуулиа хүчингүй болгоод, дахиж өргөн барих гээд явж байна. Өнөөдөр 12 дугаар сарын 02-ны өдөр. 9 сар бүтэн, 10 сар бүтэн, 11 сар бүтэн. 90 хоног төсөвтэй холбоотой асуудлаар бид ярьж байна. Тэгэхэд та өнөөдөр ийм хариуцлагагүй зүйл ярьж болохгүй. Судлах, унших боломж олдохгүй байна л гэдэг зүйлийг яриад байдаг. Өнөөдөр бид нар тэс өөр юм ярих гээд сууж байгаа зүйл байхгүй шүү дээ. Өмнө хэлэлцээд баталчихсан төсөв дээрээ тодорхой хэмжээний өөрчлөлт, урсгал зардлыг танах боломж нөхцөлүүдээ бүрдүүлээд оруулж ир гэдэг байдлаар Засгийн газарт үүрэг өгчхөөд сууж байгаа юм. Одоо бид харин хариуцлагатай хандах ёстой. Таны саяын гаргаж байгаа санал бол ирэх жил тэтгэвэр нэмэхгүй, цалин нэмэхгүй, энэ жилийн байгаа байдлаар нь явуул гэдэг саналыг хэлээд, тэр нөхцөл рүү оруулахын тулд хуульд өөрчлөлт оруулах санал гаргаж байна. Энэ ерөөсөө болохгүй зүйл шүү. Бид хуульд захирагдаж ажиллах ёстой. Хугацаанд захирагдаж ажлаа хийж байх ёстой. Түүнээс биш өөрсдийнхөө хариуцлагыг тэр чигт нь нээж хаячхаад, бүх асуудал дээр хөндлөн хэвтээд сууж байх тийм нөхцөл рүү хэрхэвч орж болохгүй.

Улсын Их Хурлын гишүүд маань хуулиар хүлээсэн үүргийнхээ хэрэгжилтийн төлөө бас анхаарал тавьж хандана шүү. Бас нэг зүйлийг бас их сайн анхаарах хэрэгтэй. Маш олон гишүүд ажил хэрэгч саналыг гаргаж байгаа шүү дээ. Маш олон гишүүд. Тэр ажил хэрэгч саналыг Засгийн газар, холбогдох Байнгын хороо, ажлын хэсэг авч байх ёстой. Бас үүний хажуугаар зүгээр ажлыг удаашруулах гэсэн улдан эсэргүүцсэн ийм байдлуудыг огт гаргаж болохгүй. Энийг маш хариуцлагатайгаар Байнгын хорооны дарга нар Байнгын хороодын хурал дээр, ажлын хэсгийн дарга

ажлын хэсгийнхээ хурал дээр хагалж байх ёстой. Нэг талдаа шийдэж байх ёстой. Тэгэхгүйгээр тэгээд Улсын Их Хурал 1 хэлэлцсэн асуудлаа удаа дараа Байнгын хороо дээр ч нэг яриад л хэрүүл болоод л, ажлын хэсэг дээр ч нэг ярьж, хэрүүл болоод л, Улсын Их Хурлын чуулган дээр орж ирж дахиж хэрүүл болгодог энэ байдлыг хэдүүлээ бас нэг жоохон хэмжээ хазаартай хийхгүй бол энэ Улсын Их Хурлаас чинь хамаарсан улс орон, ард иргэдийн амьдрал, хувь заяаны асуудал байнга явагдаж байдаг гэдгийг бодох хэрэгтэй шүү.

Сангийн сайд Болдын Жавхлан энэ дээр хариулт өгье.

Б.Жавхлан: Золжаргал гишүүний асуултад нэмж хариулъя. Амарбаясгалан дарга бараг хэлчихлээ. Золжаргал гишүүн маань ер нь ингэх гээд байна л даа. Төсөв батлахгүй байх, ингээд л үргэлжлээд л бүтэн жил ч хамаагүй хэлэлцэж болох тэр орон зайг л, цонхыг л нээж өгөх гээд байна л даа. Уг нь энэ чинь ингээд нэг хариуцлагаар ч юм уу, цаг хугацаагаар энэ чинь бас хязгаарлачихсан юм байгаа байхгүй юу. Тэгэхээр 3 сар хэлэлцлээ, ер нь багадаад байна. Он гараад хэлэлцье. Цагаан сар өнгөртөл хэлэлцье. Тийм одоо бүр бүтэн жил тойроод дараагийн жилийн төсөв хүртлээ хэлэлцдэг больё л гэдэг тийм цонх нээж өгөх гээд байх шиг байгаа юм. Тэгж болохгүй. Тийм, тэрийг зарчмын хувьд ерөөсөө бүр категорический ерөөсөө тэгж болохгүй асуудал. Тийм учраас тэр саналыг тэр санал гарахгүй байгаа. Сая Төсвийн байнгын хорооноос асууна лээ. Зүгээр миний хувьд, гишүүний хувьд ч тэр, Засгийн газрын гишүүний хувьд ч тэр, ийм бодолтой байдаг. Тийм. Сая Их Хурлын даргатай санал ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тэгээд нөгөө талдаа Жавхлан сайд аа, ийм шүү. Энэ парламентын гишүүд бас 126 болчихсон. Олон салбарыг төлөөлсөн мэргэжлийн хүмүүс орж ирчихсэн. Бас энэ төсөвтэй холбоотой асуудлыг бүх түвшинд нь бас нэлээдгүй үзэж, харж, судалж байгаа ийм зүйл бас маш тодорхой ажиглагдаж байгаа юм. Тэгэхээр өнөөдөр бид анх удаа энэ 126 гишүүнтэй парламентын төсөв батлагдаад, буцаагаад төсвийн хуулиа хүчингүй болгосон процесс явагдчихсан байж байгаа юм. Шинээр өргөн барих төсөв өөрөө энэ Улсын Их Хурлын гишүүдийн тавьж байгаа шаардлагуудыг маш өндөр түвшинд харгалзан үзсэн байх ёстой. Тэр ч утгаараа өнөөдөр энэ намын бүлгүүд дээр өргөн барихаас өмнө ерөнхий зарчмаа тогт гэж байгаа чинь, их зөв байр суурь шүү.

Харин гишүүд маань ерөнхий зарчим агуулга гэж юу байх вэ, улсын төсвийн үүрэг оролцоо гэж яг юу байх вэ гэдгийг ерөнхий утгаар нь бас харж сурах ёстой. Тэгэхээр энэ дээр сая Золжаргал гишүүний үгэнд бас гарч байна шүү дээ. Амьдрал баян гэж байгаа юм. Улс орны эдийн засаг жилээс жилд улам бүр тэлж байгаа. Инфляц жилээс жилд өсөж байгаа. Тэгэхээр нөхцөл байдлуудаа бид их олон талаас нь бодно шүү. Сая бид нэг зүйлийг ярьсан шүү дээ. Анхдугаар Үндсэн хууль батлагдсан 100 жилийн ойг сая тэмдэглэхдээ 100 жилийн өмнө Үндсэн хуулиа баталж байсан тэр цаг үеийг бид шүүх боломжгүй гэж байсан. Тэгвэл өнөөдөр бид бас ковидын цар тахлын цаг үе буюу 2020, 21 оныг өнөөдөр 25 оны төсөвтэй харьцуулалт хийгээд байх бас их шууд утгаараа бүрэн боломжтой юу, үгүй юу гэдгийг ч бас бид олон талаас нь харах хэрэгтэй. Мэргэжлийн хүмүүс учраас энэ дээр олон талаас нь харж асуудалд хандах ёстой шүү гэдгийг бас энэ ташрамд хэлье.

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууя.

Золжаргал гишүүн тодруулга.

Ж.Золжаргал: Түрүүн Их Хурлын дарга хэллээ шүү дээ. 9 сараас хойш л хэлэлцэж байгаа гээд. Тэгээд яг энэ дээр л би хэлэх гээд байна л даа. Анх удаагаа ийм зүйл болчихлоо. Тэгээд дахиад анх удаагаа юу ч болохыг бас мэдэхгүй. Тийм болохоор ямар нэгэн байдлаар хугацаа хоцроод ингэхэд үр дагавар нь үндэсний хэмжээний хямралд хүргэдэг байж болохгүй гэж. Энэ дээр л та бүхний анхаарлыг хандуулж байгаа шүү.

Д.Амарбаясгалан: Зөв өө, зөв. Бүтэн харах ёстой. Тэрийг ойлгож байна, санал нэг байна.

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууна.

Ж.Чинбүрэн: Эрхэм гишүүддээ энэ өглөөний мэнд хүргэе. Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг дэмжиж байна. Харин зүгээр энэ хууль төсөв оруулж ирэхтэй холбоотой Засгийн газарт бас нэг сануулга хэлчихье гэж бодоод байгаа юм. Яагаад гэхээр одоо та бүхэн Засгийн газар төсвөө оруулж ирэхдээ мэдээж алдагдлуудаа танана, хянана. Эрүүл мэндийн салбар бол онцгой байгаа шүү. Ялангуяа ковид цар тахлын үед ЭМД-ын сан 260 гаруй сая төгрөгийн тэрбум төгрөгийн алдагдалтай. Үүнтэй холбоотой даатгалын сан мөнгө нь хүрэхгүй, эрүүл мэндийн байгууллагууд хийсэн гүйцэтгэлээ авч чадахгүй, мөн ханган нийлүүлсэн байгууллагууд нь 400 гаруй тэрбум төгрөгийн авлагатай болчихсон. Энэ асуудал бол үнэхээр ноцтой асуудал байгаад байна аа.

Тийм учраас би бас төсвийн ерөнхийлөн захирагч Эрүүл мэндийн сайдад бас энэ онцгой анхааруулж, эрүүл мэндийн салбараас танаж болохгүй ээ. Тийм, энэ таналт бол эрүүл мэндийн салбараас хасах юм бол энэ үнэхээр ноцтой зүйл болно шүү. Энэ дээр бас онцгой анхаараарай гэж бүр зориуд сануулж хэлмээр байгаа юм.

2-т, зарим албан тушаалтнууд бас тэгж ойлгоод байх шиг байгаа юм. Ер нь зүгээр нэг эрүүл мэндийн салбар бол зүгээр л мөнгө хийгээд, буцаад өгөөжөө өгдөггүй, ашгаа өгдөггүй ийм салбар шүү дээ гэсэн тийм байр сууриас хандах гээд байх шиг байна. Тийм биш шүү. Монгол хүн эрүүл байж байж, татвараа төлж энэ төсвийг чинь бүрдүүлж байгаа. Тийм учраас Монгол хүний эрүүл мэндийн төлөө энэ өвчин зовлон тусаад хурдан эдгэрэх, эрт илрүүлдэг байх, олон олон халдварт өвчнийг устгах байхын төлөө энэ төсөв дээр таналт эрүүл мэндийн салбарт яагаад ч хийж болохгүй.

Жавхлан сайд бас тэгж хэлж магадгүй. Зүгээр салбар болгон ингээд яриад байж болохгүй гэж магадгүй. Тийм биш шүү. Энэ бол 3,5 сая хүний эрүүл мэндийн асуудлыг яаж байгаа зүйл учраас төсвөө оруулж ирэхдээ та бүр энэ дээр онцгой анхаараарай. Ялангуяа эрүүл мэндийн тусламжийн асуудлыг шийдэх ёстой, тэр ЭМД-ын өрийн асуудлыг бас нэг тодорхой хэмжээгээр шийдчихсэн ороосой гэж бас хүсэж байгаа юм. Энэ дээр анхаарал тавиасай гэж хүсэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Жадамбаагийн Баясгалан гишүүн асуулт асууя.

Ж.Баясгалан: Засгийн газраас яаралтай хэлэлцүүлгээр орж ирсэн Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай төслийг хэлэлцэхийг дэмжиж байна. Ер нь цаашид Улсын Их Хурал жилийн төсвийн тухай хуулийг Төсвийн тухай хуулийг хуульд заасан үндэслэлээр хүчингүй болгосон бол Засгийн газар хэд хоногийн дотор төслөө Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байх талаар энэ хуулийн төсөлд тусгагдаагүй байгаа, дэг дээр бол байгаа. Тэгэхээр энэ талаар хариулт авъя. Ер нь

магадгүй Засгийн газар ажлын 5 хоногийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гээд яг хугацаа заачих юм бол энэ Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд уг асуудлыг хэлэлцэх дэгийг тодорхой болгоод, цаглавраа гаргах боломжтой болно. Тэгэхээр энэ дээр хууль дээрээ ингэж хугацаа тусгах боломжтой юу гэж асуулт асууж байна.

2 дугаарт гэх юм бол Ерөнхийлөгч 2025 оны төсвийн тухай хуульд бүхэлд нь хориг тавьсан. Тэгэхдээ энд байгаа тэр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5.1.6-д заасны дагуу төсвийн хөрөнгийн хуваарилалт, байршуулалт, хэрэглээ нь эдийн засгийн болон нийгмийн ач холбогдолтой байх заалтуудыг бүрэн хангаагүй байна гэсэн байгаа. Тэгэхээр энэ заалтууд дээрээ бас их анхаараасай. Засаг маш их шахуу хуралдаж байгаа. Энэ хэмжээгээрээ хасахдаа энэ заалтаа зөрчөөд бас нийгмийн энэ гол зүйлээ хаячих вий гэдэг дээр бас сануулж байна.

Тэгээд түрүүн Чинбүрэн гишүүн хэллээ. Үнэхээр бидний хөндөж болохгүй нэг салбар бол яалт ч үгүй эрүүл мэндийн салбар байгаа. Эрүүл мэндийн салбараасаа хөндөхгүйгээр бид нар яаж төсвийг танаж болж байна аа. Тэр талд сайд нар минь хичээнгүйлэн ажиллаж үзээрэй. Эрүүл мэнд, Монгол хүний амь нас, амьд явах, амьд байх эрх чөлөөтэй холбоотой учраас энэ эрүүл мэндийнхээ салбараас ерөөсөө таналт хийж болохгүй шүү гэж хэлье.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Тийм, Баясгалан гишүүнтэй ер нь санал нийлж байна. Ер нь Засгийн газрын өргөн барьсан энэ төсөв маань үеийн үед л хөгжлийн төлөө ийм зорилго байдаг. Төсвийн тухай хуулийн өөрийнх нь үндсэн зарчим тэр. 2 суурь зарчим байгаа юм.

1 дүгээрт, Засгийн газрын үйл ажиллагааг аливаа доголдолгүйгээр бүрэн санхүүжүүлэх.

2 дугаарт, энэ эдийн засгийн өсөлт, эдийн засгийн дэмжлэгт төсвийн бодлогоор дэмжлэг үзүүлэх үндсэн 2 суурь багана зарчим байна. Нэгэнт ингээд хөгжлийнхөө хөтөлбөрийг, хөгжлийнхөө төлөвлөгөөг батлаад, тэрийгээ санхүүжүүлэхтэй нийцсэн төсөв яг өргөн баригдсан байдаг. Энийг яг тоогоор нь харж байгаад арифметик утгаар нь хасаад тооцоод, алдагдалгүй төсөв гаргаж ирэхэд маш амархан. Энэ захын оюутан хийгээд гаргаад ирнэ. Харин нэг төгрөг болгоны цаана энэ үйл ажиллагаа, арга хэмжээ, хөтөлбөр байдаг. Тэгэхээр одоо танасан тохиолдолд, хассан тохиолдолд санхүүжилтгүй болсон хуулийн заалттай, хөтөлбөрийн заалттай, үйл ажиллагаатай ийм зүйлүүдийг яах вэ гэдэг маш том бодлогын асуудал онгорхой үлдэнэ. Тэр болгоныг шийдэж оруулж ирэх бас цаг хугацаа бидэнд байхгүй.

Тэгэхээр төрийн гүйцэтгэх зарим чиг үүргийг хувийн хэвшлээр яаж гүйцэтгүүлэх вэ, алийг нь хойшлуулах вэ, яаж эрэмбэлэх вэ гээд маш олон асуудлууд дараагийн ийм сорилтууд гарч ирнэ. Тэгээд аль болох чадлаараа энийгээ шийдээд оруулж ирэхийг л хичээж ажиллаж байгаа. Өөрөөр хэлбэл үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ энэ бүгдийг орхихгүйгээр хаа нэгтэйгээр гадаадын хөрөнгө оруулалтаар, төр хувийн хэвшлийн түншлэлээр ч юм уу, зарим чиг үүргээ хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх ч юм уу гээд маш олон хувилбарууд тэр Засгийн газар ингээд төсвийн ерөнхийлөн захирагч нар, сайд нар маань ингээд ажиллаж байгаа.

Тэгэхээр аль болох л нийгмээс хүлээж байгаа тэр хөтөлбөр, үйл ажиллагаа, нийгмийн хөгжилд дорвитой нэмэр болох энэ бүх зүйлүүдээ орхихгүй байх дээр л хичээж явна. Мэдээж зардал энэ төсөв тал дээрээ цаашаа алдагдалгүй байх энэ чиглэл рүүгээ ч бас давхар явцгаахаар л бүгдээрээ шийдлээ шүү дээ. Тэгээд энэ бүгдийнх нь балансыг нь барьж орж ирнэ л гэдэг одоо дараагийн төсвийн том сорилт байна л гэж хэлье.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын дэд дарга Булгантуяа гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг энэ 7 хоногт хурлаа хийгээд эхэлж байгаа. Энэ төсөв хэлэлцэхтэй холбоотой, төсвийн гүйцэтгэл тайлан хэлэлцэхтэй холбоотой, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, мөн Төсвийн хууль зэрэг хуулиудын цаглаврын нийцлийг хангах, хоорондын зөрчлийг арилгах энэ ажил нэг талдаа хийгдэнэ.

2 дугаарт нь, өчигдөр Сангийн сайд бас мэдээлэл ирүүлсэн. Нийт гишүүдэд өнөөдөр очиж байгаа болов уу гэж бодож байна. Нийтдээ 56 хуулиар төсөв зохицуулдаг болчихсон, салбар салбарын. Тэгэхээр энэ хуулиудыг бас цэгцлэх ажил хийгдэхгүй бол Сангийн яам ганцаараа төсөв зохиодог биш салбарын яамнууд салбарынхаа хуулийн дагуу төсөвт зайлшгүй тусгах ёстой зардлуудыг бий болгочихсон байгаа нөхцөл байдал байж байгаа юм. Тэгэхээр энэ 2-ыг бид Их Хурал ойрын хугацаанд засаж залруулах 1 дэх үүргийг хүлээж байгаа юм.

2 дугаарт нь, Сангийн сайд, ялангуяа Засгийн газар энэ дээр маш сайн онцгой анхаарах ёстой. Дараа жилийн орж ирэх төсөв, энэ удаагийн Улсын Их Хурлын гишүүдийн хөндөж байгаа агуулга, алдаа дутагдлуудыг засаж залруулахад онцгой анхаарсан байх ёстой гэдгийг л маш сайн анхаарах хэрэгтэй. Тэгж чадаагүй тохиолдолд дараа жилийн төсөв мөн адил батлагдахад хүндрэл үүснэ гэдгийг л энэ удаа бид сургамж болгож авах ёстой. Ер нь 126 гишүүнтэй болсны давуу тал яаж гарч байна вэ гэхээр энэ төсвийг ер нь төсөв гэлтгүй аливаа хуулийг маш олон өнцгөөс нь хэлэлцэж чадаж байна. Олон гишүүд олон өнцгийг хөндөж, гаргаж ирж, нийгмийн сэдэв болгож чадаж байна шүү дээ. Тэгэхээр энэ давуу байдлыг бид Улсын Их Хурлаас гарч байгаа шийдвэр илүү тунгалаг, илүү чанартай, илүү урт удаан настай байх тэр боломжийн төлөө алхана л гэсэн үг болж байгаа юм. Түүнээс дараа жил, нэг жил гишүүн болчихсон дасчихсан юм чинь одоо яах вэ энэ удаа аргалаад өнгөрчихье гэдэг бодол, бодлого бол байх боломжгүй болчихсон байна аа.

Тэгэхээр л энэ бүгд дээр мэргэжлийн түвшинд хандах хэрэгтэй болж байна. Энэ гишүүдийн тавиад байгаа парламентын түвшинд хэлэлцүүлэг өрнөөд байгаа сэдвүүд дээр онцгой анхаарах шаардлагатай болж байна гэдгийг бас энэ удаа бид сургамж болгож авах ёстой шүү.

Ингээд Батжаргалын Заяабал гишүүн асуулт асууя.

Б.Заяабал: Баярлалаа. Та бүхэндээ бас өглөөний амгаланг айлтгая. Энэ жилийн төсвийн хувьд хэлэлцэхтэй зэрэгцээд их олон жил, олон үйл явдал энэ жил тохиолдлоо л доо. Сонгууль боллоо. Сонгуулийн дараа үр дүнгээр шинэ Засгийн газар байгуулагдлаа. Хамтарсан Засгийн газар байгуулагдлаа. Хамтарсан Засгийн газрын бүтэц байгуулагдлаа. Хамтарсан Засгийн газрын хэрэгжүүлэх Засгийн газрын үйл ажиллагааны 4 жилийн хөтөлбөр батлагдлаа. Шинэ Засгийн газрын үйл ажиллагааг явуулах боломжийг нээх үүднээс шинэ тодотголыг, төсвийн тодотголыг оруулж ирлээ. Энэ тодотгол нь хамгийн гол нь энэ шинэ Засгийн газрыг бүтэц бүрэлдэхүүний хувьд цаашаа үйл ажиллагааг нь явуулах гэхээсээ илүү, томоохон

бодлогын ийм шинэчлэлийг бас энэ шинэ тодотголоор дагаж орж ирсэн. Төсвийн хүрээний мэдэгдэл дээр бас өөрчлөлт оруулсан. Энэтэй холбоотой орлогын, зарлагын, тэнцлийн, өрийн гэх мэтчилэн хязгаарууд дээр өөрчлөлтүүдийг оруулж ирж өгсөн. Энэ нь өөрөө төсвийг тэлэх бас боломжийг бий болгож өгсөн. Ингээд төсвийн тодотголыг дагаад 2024 оны төсвийн гүйцэтгэл сайн байсантай зэрэгцээд орлого, зарлага 2 талдаа хоёуланд нь ингээд төсөв тэлэх ийм боломжийг бий болгож өгсөн.

Өнөөдрийн 25 оны төсөв яг энэ 24 оны тодотгосон төсөв дээр үндэслээд хийгдэхээр зэрэг дахиад 25 оны төсөв ингээд нэмэгдээд, тооцоо нь хийгдээд явж байгаа гэж ингэж харж байгаа юм. Тэгэхээр бид нар энэ төсвийг, шинэ төсвийг хэлэлцэхтэй зэрэгцээд дараагийн нэг өөр асуудал нь юу болсон юм бэ гэхээр зэрэг энэ шинэ төсөв бас урьд өмнөх төсвүүдээсээ ялгаатай нь маш их олон талын оролцоог хангасан ийм төсөв байгаа. Төсөв боловсруулах шатдаа, батлах шатдаа маш их олон оролцоонуудыг хангаж байгаа. Төсөв боловсруулах шатдаа яамнууд Засгийн газруудын саналууд оролцоонуудыг гаргахаас гадна Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бас төсвийг боловсруулах шатад орж ирж байгаа юм. Гэтэл яг энэ төсвийн боловсруулах шат дээр орж ирж байгаа Төсвийн төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт нь өөрөө хийгдсэн тооцоо, судалгаа, макро эдийн засгийн үзүүлэлтүүд нь хоорондоо Засгийн газрынхтай зөрөөд, тэрнээсээ холбоотойгоор Их Хурал дээр бас ингээд ойлгомжгүй байдлыг бий болгочхож байгаа юм.

Төсөв боловсруулах шат дээр орж ирж байгаа дараагийн нэг зүйл бол иргэд, олон нийтийн байгууллагын оролцоог бас хангаж өгсөн байгаа. Энэ иргэд, олон нийтийн оролцоог хангахын тулд хууль дээр 28-ын штрих заалт дээр энэ салбар салбарын хэлэлцүүлгийг зохион байгуулах асуудал орж ирж байгаа. Энэ нь цааш цаашдаа илүү төгөлдөршөөд иргэд, олон нийтийн оролцоо өшөө илүү нэмэгдээд явна гэж ингэж харж байгаа юм.

Төсвийг бас 09 сарын 01-нд өргөн барьдаг болсон. Манай Улсын Их Хурал гэхэд анх 10 сарын 01-нд энэ төсвийн хэлцлийг, хэлэлцүүлгийг анх хийж эхэлсэн. Ингээд жилийн төлөвлөгөөгөө баталсны дараагаар жилийнхээ төсвөө хэлэлцье гээд ингээд бас тодорхой хугацаагаар бид нар хойшлуулаад төсвөө хэлэлцэж явсан. Тэгэхээр энэ дээрээ бид нар сургамж аваад 09 сарын 01-нээсээ өгсүүлээд салбар салбарын хэлэлцүүлгийг, магадгүй тэр Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулаад, салбар, салбарын хэлэлцүүлгийг Засгийн газрын хэмжээнд биш Их Хурлын мэргэжлийн Байнгын хороодын хэмжээнд ч юм уу зохион байгуулж явдаг бас ийм хэлбэр лүү орж явах нь зөв байх гэж ингэж бодож байгаа гэдгийг хэлье.

Мөн түүнчлэн шинээр байгуулагдсан Засгийн газрын хугацаанд Засгийн газар анх оруулж ирж байгаа анхны бүтэц дээр суурилсан төсвийг оруулж ирэхдээ энэ төсвийн тодотголыг дагаж том бодлогын өөрчлөлтүүд оруулж ирдгийг больё. Засгийн газрынхаа бүтцийгээ дагаад төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсөв хэлж шилждэг ийм бодлогыг оруулж ирдэг. Яг анхных нь төсөв дээрээ буюу яг энэ дараа жилийнх нь төсөв дээрээ төсвийнхөө том бодлогыг яриад явдаг ийм өөрчлөлт хийх шаардлагатай байна гэдэг нь эндээс харагдаж байгаа юм. Энэ дээр манай гишүүд бас анхаарч дараа дараагийн хуулиуд дээр өөрчлөлт хийх дээр бас анхаарч явахыг бас санал болгож байна гэдгийг хэлье.

Ингээд нэг 3 асуулт байгаа. Би дараагийнхаа 1 минутыг бас авахыг хүсэж байна.

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье. Батжаргалын Заяабал гишүүнд.

Б.Заяабал: Энэ дээр 1 дүгээрт нь, энэ манай хууль дээр, одоо орж ирж байгаа хууль дээр энэ хүчингүй болгосон гэдэг ийм зүйл орж ирээд байгаа юм аа. Миний хувьд энэ манай төсвийн хууль бол Ерөнхийлөгч хориг тавиад, бүрэн яг энэ хэрэгжиж эхлээгүй, төсөв батлагдах процесс нь явагдаж байгаа гэж ингэж ойлгож байгаа. Ерөнхийлөгчийн хориг тавих хугацаа дууссаны дараагаар эцсийн найруулга явдаг. Эцсийн найруулга сонссоноор хууль батлагдсанд тооцдог. Гэтэл бид нар яг энэ болж байгаа процессын үед нь хуулиа хүчингүй болгоод явчихсан юм шиг ингэж харагдаж байгаа юм. Тэгэхээр энэ дээрээ яг энэ хуулийнхаа найруулга дээрээ бас энэ дээр Ерөнхийлөгчийн хориг гэдгийг тодорхой оруулж ирж өгвөл яасан юм бэ гэдэг 1 дүгээр санал байгаа.

2 дугаарт нь, төсөв дагаж маш олон чиглэлүүдийг Засгийн газарт бид нар үүрэг болгож өгсөн. Энэ чиглэлүүдийгээ одоо энэ оруулж ирэх төсөв дээрээ оруулж ирж амжих уу гэдэг ийм асуулт байгаа юм. Жишээлбэл, нэмэгдсэн өртгийн албан татварын босгыг нэмэгдүүлэхтэй холбоотой чиглэлийг Улсын Их Хурлын тогтоолоор Засгийн газарт өгөгдсөн байсан. Энэ асуудал маргааш өргөн баригдах энэ төсөв дээрээ орж ирж амжих уу?

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн хариулъя. Хууль батлагдчихсан байх процесс явагдаж байхад хууль хүчингүй болгочихлоо гэж асууж байна.

Ц.Даваасүрэн: Тэр юуг нь бол. Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авахаар 2 нөхцөл байдал үүсэж байгаа юм. Нэг бол хуулийг хүчингүй болгох, хориг тавьсан хуулийг. Нөгөөдөх нь нэмэлт, өөрчлөлт оруулаад явах. Тэгэхээр бидний гаргасан шийдвэр энэ төсөв. Төсөв дээр нэмэлт, өөрчлөлт гэдэг бол тодотголын хэмжээнд яригдах учраас боломжгүй зүйл. 2005 онд бас л хэсэгчилсэн хориг тавигдахад мөн нэмэлт, өөрчлөлт гэдэг асуудал яригдсан учраас бас яг энэтэй ижилхэн буцаасан байгаа. Тэгэхээр хүчингүй болгоод, бид нар бүхэлд нь хориг тавьсан учраас хүчингүй болгоод тухайн хуулийг хууль санаачлагчид нь буцаасан гэж ингэж ойлгож болно.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Заяабал гишүүний асуултад хариулъя. НӨАТ-тай холбоотой босго өөрчлөх асуудлуудыг хэдүүлээ бас хугацаа байгаа. Манай Татварын ерөнхий газрын даргын үүргийг олон жил хийсэн хүний хувьд та маш сайн ойлгож байгаа байх. Тэгэхдээ энэ бас нэлээн тийм суурь бас тогтолцооны асуудал учраас нэлээн бас хэдүүлээ судалцгаая. Зүгээр босгыг жигд өндөр болгох уу, эсвэл татвар төлөгчид өөрсдөд нь сонголттой байх уу гээд тэр чинь НӨАТ-аас зугтааж байгаа нэг хэсэг байна. НӨАТ руу оръё гэж тэмүүлж байгаа нь ихэнх нь байна, систем рүү нь. Тийм учраас энийгээ нэлээн судалж байж шийдэх нь зөв. Бидэнд мөрийн хөтөлбөрт туссан нь үнэн. Гэхдээ бидэнд мөрийн хөтөлбөрийн хувьд хугацаа байгаа. Тийм, энэ удаа шууд орж ирэхгүй.

Д.Амарбаясгалан: Батбаярын Жаргалан гишүүн асуултаа асууя.

Б.Жаргалан: Манай шинэ парламент бас маш олон шинэ жишиг тогтоож байгаа. Тэгээд энэ төсвийн тухай асуудал дээр Улсын Их Хурлын гишүүд сайн ажилласан гэж харж байгаа. Бид 07 дугаар сарын 02-нд тангараг өргөснөөсөө хойш

ерөөсөө 23 оны төсвийн гүйцэтгэл, 24 оны төсвийн тодотгол, тэгээд 25 оны төсөв энэ тэр гээд л ерөөсөө сонгогдсон цаг мөчөөсөө хойш л төсөвтэй зууралдлаа, төсөв ярилаа. Тэгээд энэ хугацаанд гишүүд маш олон тийм ажил хэрэгч саналуудыг гаргаж ажилласан гэж харж байгаа. Ээлжит бус чуулган дээр ч гэсэндээ жишээлбэл Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэлэлцүүлэг гэх мэтийн зүйл дээр бас ийм макро эдийн засгаа харсан тийм олон ажил хэрэгч саналууд гарсан. Гэсэн хэдий боловч бид нар өнөөдөр 25 оныхоо төсөвт хориг тавиулчихсан, хоригоо хүлээгээд авчихсан. Улмаар энэ нөгөө төсвийн тухай ерөнхий хуульдаа ингээд нэмэлт, өөрчлөлт хийх гээд сууж байна. Тэгээд энэ бас нэг ийм сонин шинэ жишиг орж ирж байна. Бид нар энэ төсвийн тухай хуульдаа төсвийн тухай хуулийг хуульд заасан үндэслэлээр хүчингүй болгосон бол гэдэг ийм сонин бас үг хэллэг оруулаад ирчхэж байгаа юм.

Тэгэхээр хуучин яадаг байсан бэ гэхээр бас энэ чинь ингээд л анх удаа болж байгаа үйл явдал шүү дээ. Тэгээд хэзээ ч бас ингээд ийм хоригийг бүхэлд нь хүлээж авч байгаагүй, хэзээ ч бид нар дахиж ийм төсөв өргөн мэдүүлэх ийм нөхцөл байдалтай тулгарч байгаагүй. Тэгээд энэ зүйл, заалтыг оруулж ирснээр бас цаашдаа энэ улс төрийн хувьд ч гэдэг юм уу, ер нь бас нэг ийм, нэг ийм сонин хаалга нээчхэж байгаа гэдгээ манай гишүүд бас ойлгож байгаа байх гэж найдаж байна. Яагаад вэ гэхээр одоо энэ Төсвийн тухай хуулийг чинь хүчингүй болгож болдог юм байна гээд бас ийм шал өөр зохицуулалтууд яваад эхэлж бас магадгүй. Тэгэхээр энэ дээрээ бас их тийм болгоомжтой хандаад, энэ нэг хуулийнхаа үг хэллэг дээр хүртэл магадгүй тэр хориг энэ тэр гэдэг үгийг нь оруулдагсанж уу, яадагсанж уу, бас нэг тийм тодорхой байдлаар илүү бүр нарийвчлах нь зүйтэй юм шиг бас харагдаж байна.

Нөгөө талаас тодорхой асуулт. Сая ингээд өнгөрсөн, тэр 07 дугаар сарын 02-ноос хойш энэ ингээд л төсөв ярих тоолонд энэ төсөв оруулж ирж байгаа субъектүүд болох Засгийн газар, энэ төсвийг үндсэндээ боосон Засгийн газар дамнан ажиллаж байгаа Сангийн сайд, Төсвийн байнгын хорооны дарга тэргүүтэй хүмүүс бол ерөөсөө л гишүүдийн хэлж байгаа үгийг сонсохгүйгээр л дайраад байсан шүү дээ. Бид нар мэдэж байна. Ингээд болж байна. Ерөөсөө ямар ч орон зай байхгүй. Энэ бүх зүйлүүд чинь болж байгаа, бүтэж байгаа, явж байгаа энэ тэр гэсээр байгаад одоо өнөөдөр бид нар ерөөсөө ингээд төсөв ч үгүй, орон нутгийн иргэдийн хурлууд болохоор төсвөө хэлэлцэх цаг хугацаа нь болчихсон ийм сонин хямралын нөхцөл байдал руу орчхож байгаа байхгүй юу. Тэгэнгүүтээ энэ саяын ингээд энэ хариуцлага хүлээх ёстой энэ бүх зүйлийг боосон, багласан тэр хүмүүс нь болохоор хэвлэлээр бас ийм хариуцлагагүй мэдээллүүд яваад л энэ төрийн албан хаагч нар ингэж ингэж цалинжих ёстой энэ тэр гээд л Их Хурал руугаа бараг юм бухаад сууж байна. Тэгэхээр энэ хариуцлагыг хэн хүлээх вэ гэдэг асуудал байна. Оруулж ирсэн Сангийн сайд нь хүлээх юм уу, Их Хурал дээрээ ажлаа авч гарч чадаагүй Төсвийн байнгын хорооны дарга нь хүлээх юм уу, ийм бас бодитой бид нар хариуцлага ярих ёстой байхгүй юу. Тэгж байж бид дараа нь иргэддээ бүх зүйлээ ийм үнэн бодитоор тайлагнах нөхцөл байдал үүснэ. Тэгэхээр энийгээ бас та нар бодооч гэж Их Хурлын гишүүддээ хэлэх байна.

Тэгээд энэ асуулт биш, санал. Хариулт хэрэггүй.

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Намын бүлэгт харьяалагддаг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс үг хэлэхээр нэрс ирсэн байгаа. Нийт 4 гишүүний үг, нэр ирсэн байна. Дамбын Батлут,

Сандагийн Бямбацогт, Сайнхүүгийн Ганбаатар, Жаргалсайханы Золжаргал, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн 5 гишүүний нэр ирсэн байгаа юм.

Нэр ирсэн дарааллаар Сандагийн Бямбацогт сайд үг хэлнэ.

С.Бямбацогт: Төсвийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжиж байгаа. Гэхдээ Улсын Их Хурал бас энэ 34 жилийнхээ түүхэнд бас анх удаа нэг ийм байдалд орчихлоо. Тэгэхээр бид бас анхаарах ёстой. Яагаад ийм байдалд орчхов. Яагаад төсөв анх удаа ингээд хугацаандаа батлагдахгүй буцаад дахиж төсвөө хэлэлцэхээр болчхов. Засгийн газар бас анхаарах ёстой, хаана хаана аа.

Тэгэхээр ингээд нэг удаа ингээд асуудал үүслээ гээд өнгөрөх биш цаашдаа бидний үүний үр дагавар бас бодох ёстой. Гэхдээ ийм байдалд орохгүйгээр шийдэх бас гарц байсан л гэж харж байгаа. Төсвийг бид 34 удаа баталсан. Улсын Их Хурал хугацаандаа баталдаг байсан. Төсөв дээр Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьдаг байсан. Хэсэгчлэн болон бүхэлд нь. Тэр үед нь зарим тохиолдолд авдаг, зарим тохиолдолд авдаггүй, хоригийг хүлээж авдаггүй. Авсан тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг оруулаад явдаг. Холбогдох Байнгын хороо. Төсөв дээр ч 10 хэдэн удаа хориг тавигдсан, 6 удаа бүхэлд нь хориг тавьсан тийм түүхтэй юм байна лээ. Бүхэлд нь хориг тавьсан үед нь бас хүлээж авч байсан, хүлээж авахгүй байсан бас байсан тохиолдлууд байсан. Хориг хүлээж авсан тохиолдолд Төсвийн байнгын хороо хэлэлцээд, Төсвийн байнгын хороогоор Засгийн газар саналаа өгөөд, үндсэндээ асуудал ингээд явчих бололцоотой байсан.

Харамсалтай нь бид нар ингээд шинэ дэг болгоод, шинэ бас төсвийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг ингээд явах гэж байна. Сая Заяабал гишүүний хэлдэг үнэн. Төсвийн хуулийн хууль тогтоох процесс явагдаж байсан. Хуулийг хууль санаачлагч өргөн барьдаг, хэлэлцэх эсэх нь шийдэгддэг, хэлэлцүүлгүүд явагддаг, эцэслэн баталдаг. Эцэслэн баталсны дараа хоригийн хугацаа өнгөрөөд хууль, төрийн мэдээлэл сэтгүүл хэвлэгдээд хүчин төгөлдөр болдог. Хориг тавигдсан нь үндсэндээ хууль эцэслэн батлагдаагүй, хүчин төгөлдөр болоогүй л явж байхад нь бид нар хуулийг хүчингүй болгочхож байгаа юм. Уул нь ингэхгүйгээр бид нар хоригийг хүлээж аваад, Төсвийн байнгын хороо хэлэлцээд, Засгийн газраас саналыг нь аваад явчихсан бол илүү бас амархан хялбархан асуудлыг урьд нь явж байсан жишгээр шийдчих байсан.

Тэгэхээр цаашдаа бас бид нар бас анхаарах ёстой байх. Өшөө илүү бас нухацтай асуудалтай ханддаг больё. Тэгэхгүй бол иймэрхүү бас алдаанууд дахин дахин гараад байж магадгүй нь ээ. Энийг 1 дүгээрт нь хэлье гэж бодож байна.

2 дугаарт нь, үүнээс болоод бас тийм үү, аймаг, нийслэл, сум, дүүрэг төсвөө хэлэлцэж батлах нь ээ. Дахиад л бас аймаг, нийслэл, сум дүүрэг дээр дахиад бид нар хэзээ төсвийг 25 оны төсөв батлагдах вэ? Түүнтэй холбоотойгоор энэ 12 сардаа багтаад энэ ондоо багтаад төсвөө батлах нэлээн тийм шахуу асуудал үүсэж байгаа. Гэтэл зарим нь мэдэхгүй, өнөөдөр бас мэдээлэлгүйгээс болоод төсвөө хэлэлцээд эхэлчихсэн зарим аймгууд явж байна, асуугаад байна. Тийм болохоор эндээс төсөв 25 оны төсөв бид нар ийм хугацаанд батлах байх. Үүнээс хойш та нар төсвөө хэлэлцээрэй гэдэг бас чиглэл бас яаралтай Засгийн газраас байдаг юм уу, Сангийн яамнаас байдаг юм уу өгөхгүй бол энэ асуудал нэлээн асуудал болох нь байна шүү. Тэгээд бас л ингээд үндсэндээ дээрээ хөлөө олохгүй бол оороо суудлаа олохгүй гэж энэ Улсын Их Хурал, Засгийн газар хэлэлцэж байгаа асуудалдаа нэлээн нухацтай, нэлээн хариуцлагатай, нэлээн бүхэлд нь цогцоор нь харж, үр дагаврыг нь харж, үр

дүнг нь харж ханддаг байхгүй бол тэгээд хөнгөн хуумгай хандсанаасаа болоод ингээд сүүлдээ анх удаагаа Улсын Их Хурал ийм эвгүй байдалд орж байна. Дахиад бас Засгийн газар төсөв өргөн барьж асуудлыг хэлэлцэх ийм асуудал үүсэж байна шүү.

Тэгээд цааш цаашдаа Засгийн газар ч тэр, Улсын Их Хурал ч тэр, энэ хэлэлцэж байгаа, Улсын Их Хурал хэлэлцүүлэх асуудалдаа бас нэлээн хариуцлагатай, нухацтай ханддаг байцгаая гэдгийг бас хэлье.

Д.Амарбаясгалан: Бямбацогт гишүүн маань түрүүчийн чуулган дээр байгаагүй учраас бас мэдээлэл дутуу байх шиг байна. Засгийн газраас орж ирсэн аливаа асуудлыг ер нь энэ Улсын Их Хурал болж өгвөл дэмжиж өгөх гэж л бүх талаар хичээж байгаа. Бүх л гаргалгаа, боломжуудыг гаргаж, ажлын хэсэг байгуулагдаж, Байнгын хороод хуралдаж, зарим тохиолдолд бүр хамтарч хуралдаж асуудлыг шийдвэрлэх гэж явж байгаа. Өнгөрсөн Баасан гарагийн хуралдаан дээр Ёс зүй, дэгийн байнгын хороо, ХЗБХ 2-ын хамтарсан хурал болоод ажлын хэсэг байгуулаад, Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг тодорхой 1 удаагийн хэлэлцэх дэгийн төсөл боловсруулж оруулж ирж, Улсын Их Хурлаар хэлэлцүүлсэн. Санал хураалтад 69 гишүүн оролцсоноос 55 гишүүн дэмжээд, 14 гишүүн дэмжээгүй. Танхимд байсан гишүүдээс. Тэр 14 гишүүн дотор ирцэд бүртгэлтэй 8 гишүүн дэмжлэг өгөөгүй ээ. Тэр нь Засгийн газрын гишүүд. Тэгээд үндсэндээ Засгийн газрын гишүүд маань Засгийн газар буцааж татаж аваад, саналаа боловсруулаад шинээр өргөн барья гэсэн байр суурьтай байгаа юм байна гэж Их Хурал ойлгосон.

Нөгөө талдаа бас энэ Улсын Их Хурлын гишүүдийг бид бас тал талаас нь ингээд шахаад хүнд байдалд оруулж болохгүй ээ. Орж ирсэн төслийг дэмжсэн гишүүд нь нэг хүнд байдалд ордог, дэмжээгүй гишүүд нь бас нэг буруу юм хийчихсэн юм шиг байдалд ордог, энэ байдал ерөөсөө байж болохгүй. Хэн манлайлал үзүүлэх ёстой юм. Олон сонгогдсон гишүүд. Хэн манлайлал үзүүлэх ёстой юм. Засгийн газарт орж ажиллаж байгаа Улсын Их Хурлын гишүүн, сайд нар. Тэгэхээр энэ бүгд дээр бид онцгой анхаарч ажиллахгүй бол цаашдаа энэ Улсын Их Хурлын босгыг амар давахгүй болсон гэдгийг тал талдаа бас ойлгох цаг нь болсон шүү гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх.

Өнөөдөр магадгүй, би их олон үг хэлээд байж магадгүй. Яагаад гэвэл энэ Улсын Их Хурлын байр суурийг хамгаалж, бас энэ Улсын Их Хурлын явагдаж байгаа үйл ажиллагааг олон нийтэд зөв ойлгуулах шаардлага бас байгаа. Улсын Их Хурал чадамжгүй болчихсон мэт, Улсын Их Хурал асуудлаа хэлэлцэж шийдвэрлэж чадахгүй байгаа мэт асуудалд хандаж болохгүй. Харин энэ Улсын Их Хурлын гишүүд чинь энэ олуулаа болж, мэргэжлийн олон экспертүүд орж ирсний үр дүнгээр аливаа асуудлыг маш өргөн хүрээгээр хөндөж чаддаг болж байгаа юм. Маш өргөн хүрээгээр хэлэлцэж байна шүү дээ. Тэгээд энийг бид их олон талаас нь харж, зөв талыг нь дэмжиж, мэдээж буруу зүйл байвал шүүмжилж явах ёстой.

Харин нэг зүйлийг бид онцгой анхаарах ёстой. Улсын Их Хурал, Засгийн газар гээд талцаж байгаа хэлбэрийг огт үүсгэж болохгүй. Энэ чинь нэг л төр. Бид бүгдээрээ ард иргэдээсээ, сонгогчдоосоо сонгогдсон, үүрэг хариуцлага хүлээж байгаа гэдгээ бүх талдаа хариуцлагатай ухамсарлах ёстой гэдгийг бас та бүхэндээ хэлье.

Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн үг хэлнэ. Уучлаарай индэр дээрээс үг хэлэх юм байна. Дэгийн хуулийн дагуу. Хэлэлцэх эсэхтэй холбоотой асуудлаар Улсын Их Хурлын гишүүд дэмжсэн болон дэмжээгүй байр суурийг илэрхийлэхдээ индэр дээрээс үг хэлнэ гээд заасан байгаа.

Л.Мөнхбаясгалан: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, та бүгдийг нэгэн хүмүүнлэг шийдвэр гаргахад уриалах гэж би энэ үгийг хэлж байгаа. 2025 оны улсын төсөв дээр ХСҮТ эмнэлэг дээр ямар ч төсөв тавигдаагүй. Энэ эмнэлгийн барилгын зураг төслийг 3 тэрбум төгрөгөөр Бодь групп хийхээр болсон. Зураг нь бүрэн гараагүй учраас 2025 оны улсын төсөвт 1 ч төгрөг тавигдаагүй юм аа. Жил болгон Монголд 7244 хүн хавдрын өвчнөөр өвчилдөг. үүнээсээ 4556 хүн нь нас бардаг. Хэрвээ бид нар Хавдар-2 төслийг 1 жилээр хүлээх юм бол 4 мянга гаруй иргэнийхээ амь насаар дахиад 1 жил бид хүлээх нь ээ. Тэгэхээр энэ төслийг огт хүлээлгэж болохгүй, мөнгийг нь тавиад явуулах хэрэгтэй байна.

Тийм учраас Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ, Сангийн сайд Жавхлан, Эрүүл мэндийн сайд Мөнхсайхан нарт хандаж нэр бүхий 12 гишүүн гарын үсэг зурсан юм. Сая гишүүдээр явж гарын үсэг зуруулж байхад одоо нийтдээ 24 гишүүн болсон. Төсвийн 2 дугаар шатын хэлэлцүүлэг дуусчихсан байх үед Хавдар судлалын эмнэлгийн өргөтгөл сити томографыг авч өгч байсан түүх энэ парламентад 2015 онд байсан. Тухайн үед шийдэлцэж байсан гишүүдээс маш цөөхөн гишүүд энд үлдсэн байна. Тэгэхээр бид нар нэгэнт улсын төсвийг Төсвийн тухай хуулийг хүчингүй болгоод, дахиад эхнээс нь бид нар хэлэлцэж байгаа учраас жил болгон нас барж байгаа 4500 гаруй иргэнийхээ төлөө нэгэн шийдвэрт хүрье гэж бодсон юм. Энэ бол төсвийг нэмж байгаа биш, тэвчиж болох зардлыг аваад, хүн ардынхаа эрүүл мэндийн төлөө 1 жилд 4500 хүний амь насыг аврахын төлөө шийдвэр гаргаж өгөөч ээ. Та бүхэн дэмжиж өгөөч ээ. Өнөөдөр Монгол Улсад хавдраар өвдөөгүй, хавдраар хэн нэгнийгээ алдаагүй айл өрх гэж байхгүй. Энэ өвчнийг би өөрөө даван туулсан хүний хувьд, энэ өвчнөөр ээжийгээ алдаж байсан хүний хувьд, сүүлийн 10 гаруй жил хавдрын эсрэг үйл ажиллагааг зохион байгуулж ирсэн хүний хувьд маш сайн мэдэж байгаа.

Тэгээд бидний зовлон адилхан, бидний нулимс адилхан, бидний хагацал адилхан. Энд сууж байгаа эрхэм гишүүд та бүхэн ч гэсэн энэ зовлонг маш сайн мэдэж байгаа. Тийм учраас тэвчиж болох зардлаас танаж, Хавдар судлалын эмнэлэг дээр 2025 онд дэд бүтцийг нь шийдэх, мөн холбогдох бэлтгэл ажлыг хангах тал дээр мөнгө тавьж өгөөч ээ Жавхлан сайд аа. Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ, Мөнхсайхан сайд нар идэвхийлэн ажиллана гэж бодож байна. Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын дарга Амарбаясгалан нар хавдрын үйл ажиллагаанд маш сайн оролцдог байсан. Монгол Улсын Ерөнхий сайд байсан, одоо Ерөнхийлөгч байгаа Ухнаагийн Хүрэлсүх энэ эмнэлгийн эхлэлийг тавьж өгч байсан. Ерөнхий сайд байхдаа.

Сая Алтаншагай гишүүнд маш их баярлалаа. Ямар ч дэд бүтэцгүй газар хавдрын эмнэлэгт газар олгосон байсныг СХД-т дэд бүтэцтэй газар шилжүүлж өгсөн байна аа. Танд их баярлалаа. Тэгээд үе үеийн Монгол төрийн эрхэм түшээдийн, үе үеийн хүмүүнлэг сэтгэлтнүүдийн дэмжлэгээр энэ төсөл явсаар байгаа. Одоо бид шийдвэрлэх цаг болсон. Тийм учраас та бүхэнд хамтдаа нэгэн түүхийг бичиж, хүн ардынхаа эрүүл мэндийн төлөө зоримог шийдвэр гаргахыг уриалж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн 2 дугаар индэр дээрээс үг хэлье.

С.Ганбаатар: Түрүүн би асуулт асуусан. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж 1 дүгээр асуулт бол хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл шаардлагатай холбогдуулж би асууж байсан. 2 дугаар асуулт хуулийн төслийн зохицуулах харилцаа хамрах хүрээ. 3 дугаар асуулт бол хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуультай хэр уялдаж байгаа вэ гэдэг дээр асуулт асуусан. Түрүүн Жавхлан сайд их чухал зүйл хэлсэн. Ерөөсөө л энэ хэлэлцүүлэг энэ төсвийн болон хуулийн хэлэлцүүлгийг хариуцлагатай чамбайруулж хийе л гэж санал гаргасан. Энэ туйлын үнэн.

Хэлэлцүүлгийн үед гишүүдийн ярьж байсан зүйлүүдийг яагаад алагчилж байгаа юм бэ. Энэ эрх зүйн орчинд нь орсон уу л гэж би асуусан. Өнөөдөр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл маш зөв зөв дүгнэлтүүд байсан. Тэдний дүгнэлтүүдийг яагаад алагчилж байгаа вэ л гэж асуусан.

Үндсэн хуулийн 20 дугаар зүйл дээр Улсын Их Хурал төр эрх барих дээд байгууллага, хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хурал хадгална гэж зааж байгаа шүү, гагцхүү. Тэгэхээр өнөөдөр энэ хууль тогтоох энэ эрх мэдлээ Ерөнхийлөгчтэй хуваалцаж байгаа үйл ажиллагаа юм байгаа юм шүү дээ. Нэг эрх мэдлийн салаа, нөгөө эрх мэдлийн салаа руугаа дамнаж орж ирж байгаа явцад энэ бол хориг зөв. Зүгээр энэ үйл явц хариуцлагатай чамбай байя, шийдвэр гаргаж байгаа явц нь чамбай байя л гэж байгаа юм.

Анх энэ төсөв орж ирэхэд миний асууж байсан нэг асуулт байна. Төсөв ард түмэн даяараа хэлэлцүүлсэн, төсвийн ерөнхийлөн захирагч болгон хэлэлцсэн. 1 ч санал орж ирээгүй гэж орж ирсэн юм шүү. Тэгэхээр энэ хэлэлцүүлгийн хууль, эрх зүйн орчин нь өөрөө дутуу байна уу, сул дорой байна уу гэдэг талаар энэ үзэл баримтлалын хувьд энэ дээр дүгнэлт хийсэн үү л гэж би асуусан. Энэ дээрээ бодож, анхаарч хандаасай. Өнөөдөр энэ хоригтой холбоотой асуудал дээр би субъектив хандсангүй, өөр дээрээ хүлээж аваад л бухимдаад л, уурлаад л бачуураад байв даа. Би объективный хандаж байна. Хэн ч байсан бай хориг байна уу, төсөв, хууль хэлэлцэхдээ хариуцлагатай чамбай байя гэж байгаа.

2-т нь, миний ярьсан зүйл гэвэл өнөөдөр шийдвэр гаргах энэ үйл явцдаа ард түмнээс шууд мандат авсан төлөөлөгчдийн тогтоосон хуулийг улсын тэргүүн дангаараа зогсоож байгаа энэ үйл явц дээр Ерөнхийлөгчийн төсөв хариуцсан, энэ асуудал хариуцсан улсууд 70 гаруй хоног өнөөдөртэй оролцвол 90 хоног л доо. 70 гаруй хоног хэлэлцэж байхад саналаа огт яагаад хэлээгүй байж байгаад ярьдаг энэ процессыг энэ хууль, эрх зүйн орчиндоо оруулсан уу, тусгасан уу, тусгаач ээ. Цаашаа хэлэлцэж явахдаа. Бичгээр 2, 3 удаа болохгүй шүү гээд энд ганцаардаж байгаа гишүүдэд хань болж бас асуудлуудаа ярьж байсан бол хориг тавих нь зөв. Зүгээр чимээгүй зуудаг нохой шиг харж харж байгаад л гэнэтхэн хориг тавина гэдэг бол энэ шийдвэр гаргах процесс хариуцлагатай байх ёстой. Ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч маань ойлголцох, зөвшилцөх, санал бодлоо солилцох гэдэг энэ механизм энэ хоригийн өмнө байдаг уу? Байдаггүй бол энийг яагаад оруулж болдоггүй юм бэ? Үзэл баримтлалын хувьд энэ 2 саналыг би та бүхэндээ хичээнгүйлэн гуйж оруулж байгаа нь Улсын Их Хурлын, Засгийн газрын, Ерөнхийлөгчийн институцүүдийн шийдвэр гаргах үйл явц хариуцлагатай, ойлголцолтой байхын төлөө энийг, энэ саналыг би хэлж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Жаргалсайханы. Дамбын Батлут гишүүн үг хэлье. 1 дүгээр индэр дээр.

Д.Батлут: Гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдөр төсвийн шинэ төслийг хэлэлцэх эсэх асуудал яригдаж байна. Тэгэхээр Монгол төр бол хувь хүний тусын тулд ажилладаг байх ёстой. Тийм учраас бид нар хүрсэн цэгээсээ ухрах боломжгүй. Магадгүй түүнээс ахиц дэвшил гаргаж байх ёстой гэж харж байгаа. Тийм учраас төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр тэтгэмжийг бууруулах асуудал байж болохгүй юм гэж үзэж байгаа шүү. Монголчуудын Монгол иргэн хүний амьдрал, амьжиргаа ямар байгааг та бүхэн бүгдээрээ бас ойлгож харж байгаа байх гэж бодож байна.

Тэгэхээр энэ дээр манай энэ Засгийн газар тодорхой бодлого гаргаж, илүү ахиулах хэмжээний асуудлуудыг л ярих ёстой. Энэ асуудал дээр анхаарч үзээрэй гэж хэлмээр байна.

2 дугаарт нь, хамтарсан Засгийн газар байгуулагдаад Монгол Улсын ирээдүйн хөгжлийн зураглалыг томоор харж, том том төслүүдийг хэрэгжүүлэхээр зорьж байгаа. Мэдээж энэ төслүүд ирээдүйд Монгол Улсын төсөв ч болоод бусад бүх зүйл дээр л том үр дүн авчирна л гэж харж байгаа. Энэ зүйлээ хэрэгжүүлэх нь хамгийн чухал байгаа. Тэгэхээр бүтээн байгуулалтын ажлыг бид нар нийгэмд хэрэгцээтэй ийм бүтээн байгуулалтын ажлууд дээрээ томоохон хөрөнгө оруулалт тавих тэр ажлаа үргэлжлүүлж, хүчтэй зоригтой хийгээрэй гэж хэлмээр байгаа юм. Ингэж байж бид нар өнөө, маргашийг аргацаасан биш илүү том хөгжлийн зураглал руу алхах болно.

Тийм учраас бас энэ дээр нам, улс төрийн бүлгүүд хоёрдмол санаагүйгээр хамтарч ажиллана гэдэгт би эргэлзэхгүй байгаа гэдгээ хэлье. Мэдээж энэ төсвийн төсөл анх өргөн барихаас авхуулаад асуудлууд яаж өрнөснийг иргэд бүгдээрээ сайн харж ойлгож байгаа байх аа. Ямар хүмүүс, ямар будилаан тарьсан энэ тэр гэдгийг. Тэгээд энэ зүйлийг бид нар цаашдаа хэрхэх вэ гэдэг тал дээр бас тодорхой бодлого гаргамаар байгаа юм. Түрүүн Ганбаатар гишүүн хэлж байна. 2 дахь шат дээрээ хэлэлцүүлгийн шатад ямар ямар байдлаар оролцож явсан бэ гээд. Эцэст нь бүр төсвөө бид нар баталж чадахгүй, ахиад шинээр өргөн барих хэмжээнд л тулчихлаа шүү дээ. Тэгэхээр энийг бид нар хэрхэх юм, цаашдаа дандаа ийм байдал гаргаад байх юм уу, үгүй юү гэдэг дээр бас анхаарах ёстой гэдгийг хэлье.

Эцэст нь нэг зүйл байгаа. Үндсэн хуульд төлөөллийн байгууллагаараа дамжиж иргэд төрийн эрх барих үйл ажиллагаанд оролцох ёстой. Дээрээс нь иргэн хүний тусын тулд төрөөс хүний эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэдийнхээ өмнө төр хариуцна гээд заачихсан. Тэгээд энэ өнгөрсөн төсвийн тухай хуулийг бид нар ингээд иргэдээс тал талаас санал асуулгаар аваад явсан. Ингээд энэ маань хүчингүй болчихсон. Одоо энэ хууль маань шинэ төсөв маань ямар нэгэн хэлэлцүүлэггүй явж байгаа л даа. Тэгэхдээ үндсэн суурь нь нөгөө урьдын төсөв байгаа. Тэгэхдээ хэн нэгэн иргэн хүн миний эрх ашиг зөрчигдлөө, би энэ, хууль эрх, төсвийн тухай хууль ийм санал оруулсан, энэ ороогүй байна гэдэг ч юм уу, ямар нэгэн байдлаар ҮХЦ дээр маргаан үүсгэх вий дээ. Ингэх юм бол бид нар ахиад л бөөн гацаанд орно. Энэ бүх зүйлийг манай энэ Засгийн газар, одоо гарч ажиллах ажлын хэсэгт ч гэсэн маш сайн анхаарч ажиллах ёстой гэдгийг хэлье. Баярлалаа та бүхэнд.

Д.Амарбаясгалан: Гишүүд үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Санал хураалт.

1. Байнгын хорооны саналаар Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураана.

Санал хураалтад 105 гишүүн оролцсоноос 94 гишүүн буюу 89,5 хувиар санал дэмжигдлээ.

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Төсвийн байнгын хороо шууд хуралдана.

Төсвийн байнгын хорооны хурал дуусангуут нэгдсэн чуулган эргэн зарлагдана.

Тэгэхээр өнөөдөр цаг хугацаатай 3 удаагийн хэлэлцүүлэг чуулганаар орох учраас тухай бүрд нь чуулганы хуралдаанаа зарлаж явна.

Гишүүд бэлэн байхыг хүсье.

11.33 цаг

ЗАВСАРЛАГА

Д.Амарбаясгалан: Чуулганы нэгдсэн хуралдааныг үргэлжлүүлье.

Төсвийн байнгын хороо хуралдаж дууссан байна.

Хэлэлцэх асуудал.

2. Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабал танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Заяабал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан Монгол Улсын Засгийн газраас дахин боловсруулж, өргөн мэдүүлсэн төсвийн төслийг Улсын Их Хурал болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-аар хэлэлцэн батлах хугацааг тодорхой болгохтой холбоотой асуудлаар санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж, санал, дүгнэлтийн хамт та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Заяабал гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Баярсайханы Солонго ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууна. Алга байна.

Жуковын Алдаржавхлан гишүүн асуулт асууна. Алга байна.

Агваанлуvsангийн Ундраа гишүүн асуулт асууна. Алга байна.

Дамбын Батлут гишүүн асуулт асууна. Асуулт давхардсан гэж байна. Батлут гишүүнийг алгасъя.

Пүрэвжавын Ганзориг гишүүн асуулт асууна. Алга байна.

Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууна.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Тэгээд энэ нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор анх өргөн мэдүүлж байсан үеийн үзэл баримтлал өөрчлөгдсөн гэж үзэж байна уу? Өөрчлөгдөөгүй гэж үзэж байгаа юм болов уу. Энэ чинь багагүй тооны мөнгөн дүн хасах ёстой учраас үзэл баримтлал нь яах юм бол оо?

Бас нэг зүйлийг асуумаар байгаа нь нөгөө аудитаас дүгнэлт гарах уу. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс дүгнэлт гарах уу гээд ийм асуулт байна.

Тэгээд хэрвээ цаг хугацааны хувьд боломжгүй гэж байгаа бол орсон нэмэлт, өөрчлөлт дээрээ зөвхөн авах ч гэдэг юм уу, нэг тиймэрхүү маягийн, ийм төсөвт энэ төсөлд тусгаж болох уу? Яагаад гэвэл тэр 2 байгууллагын маань үндсэн үүрэг бас төсөв дээр дүгнэлт, дүн шинжилгээ хийх ийм юм байгаад байгаа. Тэгэхээр энийг яаж шийдэж байгаа юм бол оо гээд.

Тэгээд энэ 8.4 дээр, байз нэг би ч сая нөгөө яараад гараад ирсэн чинь хуулиа хармаар байдаг. 8.4-ийг бүхэлд нь хүчингүй тооцохгүй гээд тэгээд байгаа шүү дээ. Тэр чинь нөгөө цаглавар байгаад байгаа тийм ээ? Тэгэхээр түүн дээр чинь болохоор, ямар ч байсан ингээд асуучихъя. Эхний 2 асуултаар. Хуулиа харахгүй бол.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Тийм. Тэгээд бас хууль санаачлагч нар эхний асуултад бас хариулна биз. Ер нь 25 оны төсвийн тухай хуульд бүхэлд нь хориг тавигдсанаар хүчингүй болчхож байгаа учраас шинээр Төсвийн тухай хуулийг өргөх ёстой. Тэгэхээр үзэл баримтлалын хувьд ч тэр шинэчлэгдэнэ гэсэн үг. Шинэ төсвийн тухай хууль өргөж байна гэсэн үг. Нэг талаараа.

Нөгөө талаараа тэр ийм учраас аудитын дүгнэлт, Тогтвортой байдлын дүгнэлт гарна.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Жудагийн Баярмаа гишүүн тодруулж асууя.

Ж.Баярмаа: Тэгээд яах вэ, би өмнө нь ч бас хэлсэн. Гишүүд ингээд байх юм. Аль хугацаанд нь ямар асуудал тавихаа сайн судалж мэд гээд байх юм. Эсвэл Ерөнхийлөгчийг бас тухайн тухайн үед нь асуудлыг тавьж байхгүй яасан юм гээд байх юм. Энэ чинь тэгээд эцсийн үр дүн харж байж л хүн чинь дараагийнхаа алхмыг хийдэг биз дээ. Би тэрийг ерөөсөө ойлгохгүй юм. Тэгээд Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө мэдээж энэ хууль юмаа судлаад л үйл ажиллагаагаа явуулдаг байлгүй дээ. Тэгээд энэ чинь, мэдээж энэ чинь, амьдрал баян. Энэ дэгийн тухай хуулиар чинь зохицуулаагүй юм юу ч байхгүй. Байхгүй учраас бид нар тэр тохирох заалтыг нь аваад, тохирох нэмэлт, өөрчлөлтүүдийг хийгээд л явж байгаа. Тэгэхээр тэр явцын дунд тэр 2 дугаар хэлэлцүүлгийн дараа ч гэсэн Засгийн газар буцааж татах боломж байсан. Тэгээд ингээд бүх юм явбал явахаар л байсан юм. Тэгсэн чинь ерөөсөө л нэг энэ нэг гишүүд ерөөсөө хаана юу хэлэхээ мэд, бод ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: 2 асуудал дээр товчхон тайлбар хэлчихье. Баярмаа гишүүн.

1 дүгээрт, Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлаар эцэслэн батлагдсан хууль, тогтоол дээр хориг тавих эрх нь бүрэн нээлттэй. Эцэслэн баталсан тохиолдолд тавих эрх нь бүрэн нээлттэй. Улсын Их Хурал, Улсын Их Хурлын гишүүд бас Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд халдах эрх байхгүй. Энэ өөрөө эцэслэн баталсан хойно хориг тавих эрх нь үүсдэг. Тийм ээ. 1 дэх зүйл.

Улсын Их Хурлын гишүүн бол дэгийн тухай хуулиар зохицуулагдаад аливаа хуулийн төслийг хэлэлцэж байгаа шатад нь саналаа гаргах, асуултаа асуух, үгээ хэлэх бүрэн эрхтэй. Энэ дэгийн тухай хуулийн зохицуулалтыг гишүүд маань бүрэн танилцах ёстой гэдэг зүйлийг дахин дахин хэлж байгаа. Төсвийн тухай хуулийг

дэгийн тухай хуулийн 9 дүгээр бүлгээр тусгайлсан дэгээр зохицуулдаг. Тэр дэг өөрөө 1, 2, 3, 4 гэсэн 4 шатын хэлэлцүүлгээр явагддаг. 1 дүгээр шатын хэлэлцүүлэг дээр Засгийн газраас өргөн барьсан төсвийн төсөл нь Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлттэй нийцэж байна уу, үгүй юү гэдгээр санал хураалт явуулдаг. Хэрвээ Улсын Их Хурлын гишүүдийн олонх нь нийцэж байна гээд санал хураагаад дэмжихсэн бол Засгийн газар луу буцаах эрх цаашдаа байхгүй болдог.

Тэгэхээр дэгтэйгээ, дэгийн тухай хуультайгаа бүрэн танилцах ёстой гэж хэлээд байгаа зүйл энд оршиж байгаа юм аа. Би түрүүн бас хэлсэн. Улсын Их Хурлын гишүүд маань маш олон ургалч үзлээр асуудалд өргөн хүрээгээр хандаж байгаад маш их талархалтай байгаа. Асуудал болгонд нухацтай хандаж байна. Энэ бол 126 гишүүнтэй болсон парламентын ач холбогдол, үр дүн. Энийгээ бид улам өргөн хүрээгээр харж, улам илүү дадлагажиж, туршлагажих шаардлагатай байгаа гэдгийг бас хэлье.

Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууна. Алга байна.

Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууна. Алга байна.

Банзрагчийн Түвшин гишүүн асуулт асууя.

Б.Түвшин: Өнөөдрийн та бүгдийнхээ өдрийн амгаланг айлтгая аа. Тэгээд нэг 2, 3 зүйлийг бас тодруулж хэлье гэж бодож байна. Ер нь бол зүү орох зайгүй төсөв байгаа. Бүгдээрээ хуультай. Тэгээд энэ эндээс нь хасаад төрийн албан хаагчид цалинтай, цалингүй болчих гээд байгаа юм шиг яриад байгаа юм. Тэгэхээр жирийн төрийн албан хаагчид буюу багш, эмнэлэг, тэр цэрэг, цагдаагийнхны цалингаас 1 ч төгрөг хасах тухай энд яриагүй байгаа. Зүгээр 2, гуравхан статистик хэлье л дээ.

2022 онд 14,2 их наядын төсөвтэй урсгал зардалтай байсан, 23 онд 17, 24 онд 21, тодотголоор 22, 25 онд 26 их наядын урсгал зардал төсөв өсөж орж ирж байгаа. Өөрөөр хэлбэл зөвхөн 24 онтой харьцуулахад 30 хувиар өсөж байгаа. Мэдээж үүний цаана цалингийн өсөлт гэж байгаа. Цалингаас бусад өсөлт нь гэхэд л 3,7 их наяд буюу 24,5 хувиар өсөж байгаа. Тэгээд энэ их төсөв өсөөд байна. Үүний чинь цаана бид нар Тогтвортой байдлын тухай хуулиа өөрчилчихсэн. Энэ Тогтвортой байдлын тухай хуулийг өөрчлөхдөө 14 мега төсөл ярьсаар байгаад л өөрчилсөн. Гэтэл 14 мега төслөөс чинь хөрөнгө оруулалтын зардал дээр 1 их наяд төгрөг бараг зураг төслийн л асуудал байж байгаа шүү дээ. Тэгээд ингээд зардал яваад байгаа юм. Ямар зардлуудын тухай яриад байна вэ гэхээрээ тэр цалин хөлс болон хуулиар холбогдсон халамж, тэтгэвэр, тэтгэмжийн тухай яриагүй шүү дээ. Одоо энэ байр ашиглалттай холбоотой зардал гэхэд л зөвхөн энэ онд 863 тэрбум болж, өнгөрсөн оны мөн үеэс 57,7 хувиар өсөж байгаа. Хангамж, бараа материалын зардал гэхэд л 281,5 тэрбум болж, 40,6 хувиар өсөж байгаа. Норматив зардал 60 хувиар, эд хогшил 119 хувиар, томилолтын зардал 107 хувиар гээд ийм зардлуудыг л яриад байгаа шүү дээ.

Тэгээд энэ зардлууд нь өөрөө зүү орох зайгүй тийм гайхалтай, сайхан зардлууд болчихсон юм уу? Ер нь манай Монгол Улсын төсөв чинь өөрөө уул уурхайгаас хамааралтай, Оюутолгой, Эрдэнэт, Тавантолгойгоос авдаг. Энэ барагддаг баялгийн нөөцөөрөө бид нар өнгөрсөн хугацаанд 1 ширхэг ч үйлдвэр бариагүй шүү дээ. Өнөөдөр бүгдээрээ эрчим хүчний дутагдалд орчихсон явж байгаа шүү дээ. Энэ урсгал зардал чинь урсгал зардал нэхээд байгаа юм. Буцаагаад энэ

байр савнууд чинь дахиад дандаа ашиглалтын зардлуудаа нэхээд, цаашдаа бид нар өнөөдрийг хүртэл 1 ч төгрөг хасаж чадахгүй хэмжээнд болтол ингээд өөрсдөө урсгал зардалдаа бид нар баригдчихаад байгаа байхгүй юу.

Тийм учраас төсвийн бүрэн реформ хийж байж, бид нар энэ урсгал зардлаа багасгаж байж, энэ уул уурхайн баялгаараа олсон мөнгөөрөө дараа дараагийн томоохон үр ашигтай болгох, улс орны хөгжилд нэмэртэй болох, олон хүмүүсийг ажлын байртай болгох, үйлдвэр сав барих тухай энэ төсвийн тодотгол өөрчлөлтийг хийхгүй бол яг ийм байдлаар урсгал зардалдаа баригдаад дуусах нь гэдгийг энд онцлон хэлмээр байна. Энэ олон нийтэд яваад байгаа зүйл ч гэсэн тэр цалингаас нь хасах гээд байгаа тухай ч юм уу, эс үгүй бол цалингүй болгох гээд байгаа тухай биш юм аа. Ер нь цаашдаа түүн рүү орох хэрэгтэй. Энэ дээр Даваасүрэн дарга тэр бүтцийн өөрчлөлт хийж байж орох ёстой гэж хэлж байсан. Энэ бол зөв. Дунд хугацаандаа явна. Гэхдээ богино хугацаандаа ийм үр ашиггүй зардлуудаа зайлшгүй хасах ёстой юм гэдгийг зайлшгүй хэлэхгүй бас болохгүй байгаад байгаа. Ялангуяа энэ уул уурхайн орлогоо.

Тэгээд хоёрхон асуулт асууя. Төсвийн тухай хуульд орж ирсэн 32.1.1 дээр хуульд заасан үндэслэлээр хүчингүй болгосон бол гэж байгаа юм. Хуульд заагаагүй үндэслэлээр өөр хүчингүй болгох боломжтой юу? Тийм тохиолдол гэж байгаа юу?

Хоёрдугаарх нь 32.1.5 дээр төсвийн жил эхлэхээс өмнө хэлэлцэж гэдгийг улсын төсөв батлагдсаны дараа тодорхой хугацаанд гэж найруулах боломжтой юу? Дахиад гацаа үүсэх боломжтой.

3 дугаарт, Ерөнхийлөгч дахиад хориг тавивал дахиад бид нар гацаанд орох уу? Өөрөөр хэлбэл энэ асуудал чинь бид нарын хуулийн цоорхой байгааг л нөхөх гэж явж байгаа болохоос биш ямар нэгэн улс төрийн хауст орчихсон зүйл биш шүү дээ. Өөрөөр хэлбэл энэ тухай хуулийн гарц гаргалгаа нь бүрэн байгаагүй учир бас нөхөж оруулж ирж байгаа ийм л процесс, ийм л үйл явдал болж байна гэж үзэж байна.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Тийм, зарим асуултад нь хууль санаачлагч хариулах нь зөв байх. Ер нь бол энэ удаагийнх дээр дэгийн тухай хуулийн 90.8-аараа бол хоригийг хэсэгчлэн болон бүхэлд нь тавьсан тохиолдолд хүчингүй болгоно, тухайн хуулийг гэж байгаа ийм заалт байгаа учраас тэрийгээ л хэлж байгаа байх. Түүнээс биш хүчингүй болгохгүй тохиолдол бол би мэдэхгүй байна. Би хууль санаачлагч тодруулах байх гэж ингэж бодож байна.

Дахиад мэдээж хориг тавих юм бол нөгөө ондоо багтахгүй нөхцөл байдал үүснэ шүү дээ. Тэгэхээр ингэж тооцож хийх үү гэдэг их төвөгтэй. Ер нь бидний үүрэг юу вэ. Төсвийг онд нь багтааж баталж, Засгийн газар, Их Хурлын гол ажил шүү дээ. Тэгээд иргэдийнхээ төсвийн байгууллагуудынхаа цалин, санхүүжилтийг хийж, үйл ажиллагааг нь тасралтгүй явуулах ёстой байхгүй юу. Тийм л асуудал.

Тийм учраас бид нар аль болох л хууль санаачлагчийн тэр оруулж ирж байгаа ондоо багтаая гэж байгаа энэ саналыг зүйтэй юм л гэж ингэж үзсэн байгаа.

Д.Амарбаясгалан: Хууль санаачлагчийг төлөөлж Санжаадорж. Ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Сангийн яам Хууль, эрх зүйн газар Энхболд Түвшин гишүүний асуултад хариулъя.

Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 90.8 дээр хууль хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах гэсэн 2 агуулга байгаа. Энэ хуулийн 90.8 дээр заасан хууль хүчингүй болгох гэсэн энэ заалтынхаа агуулгыг энэ хуулийн төсөлдөө тусгаж өгсөн юм.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Түвшин гишүүний асуултад нэмж мэдээлэл өгье. Түвшин гишүүн ээ. Хэдүүлээ уг нь бараг 90 хоног л ярилцсан даа. Ямар ямар зардлууд, ямар хуулийн заалттай, ямар тогтоолын дагуу, ямар хөтөлбөрийн дагуу, ямар үйл ажиллагааны шаардлагын дагуу орж ирдэг юм бэ гээд. Тэр байр ашиглалтын зардал бол энэ жилийн цахилгаан, дулааны үнийн өсөлтийн тарифтай л шууд холбоотой шүү дээ. Та энийг маш сайн мэдэж байгаа. Тэр 2 тариф чинь хэдэн хувь нэмэгдэж байгаа билээ? Энэ эрчим хүчний салбарын орлогын бараг 25 хувь нь төсвийн байгууллагуудаас ордог байхгүй юу. Төсвийн байгууллагуудаас ордог.

Тэгэхээр төсвийн байгууллагуудын байр ашиглалтын зардал ерөөсөө хамгийн том зардал нь ерөөсөө энэ 2 л байдаг. Тэгээд ирэх оны сая тодотголоор бид нар энэ оны эрчим хүчний хамгийн өндөр ачаалалтай байдаг эхний улирал буюу энэ оны 4 дүгээр улирал, ирэх оны 1, 2, 3 дугаар улирлууд дуустал үнийн тарифт нэмэгдэх ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Банзрагчийн Түвшин гишүүн тодруулж асууя.

Б.Түвшин: Жавхлан сайд аа, байр ашиглалттай холбоотой зардлын тухай асуулт асуугаагүй. Ер нь иймэрхүү байдлаар урсгал зардал тасралтгүй өсөөд тэгээд цаашдаа бид нар ер нь зардлаа, урсгал зардлаа хасаж чадахааргүй буюу орлогынхоо 77 хувийг л зарж байна гэдэг энэ зүгээр ярьсан юм.

Асуулт бол 32.1.5 дээр тэр төсвийн жил эхлэхээс өмнө, сум, дүүрэг, аймаг, нийслэл, сум, дүүргийн хурал тухайн шатын төсвийн төслийг дараагийн төсвийн жил эхлэхээс өмнө хэлэлцэж батална гэдгийг улсын төсөв батлагдсанаас тодорхой хугацааны дараа гэж болох уу гэж асууж байгаа. Тэгэхгүй бол дахиад энэ чинь гацаанд орчих вий дээ л гэсэн асуулт байгаа.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Түвшин гишүүн ээ, тийм асуудал байгаа. Тэгэхдээ ингээд хууль санаачлагчийн хувьд бид төслийг бичээд оруулахдаа Улсын Их Хурлын дэгээр зохицуулагддаг эсэхийг бид хамаагүй мэдэж бас зааж өгч болохгүй байгаад байгаа юм. Бид үүгээр өргөн барих хүртэлх тэр замаа ингээд арай товчилчхож байгаа шүү дээ. Нөгөө 6 сар дор хаяж хийдэг нөгөө цаглаварт багтааж хийдэг ажлаа ингээд ингээд тэрийгээ багасгаад, хэлэлцүүлэг энэ тэрийгээ 90 хоног хийлээ шүү дээ, хэдүүлээ. Анхан шатаасаа нөгөө тоонуудаа авдаг юмнууд чинь бүгд процессууд нь явчихсан. Тэрийг 0-оос эхлэхгүйгээр өргөн баригдсан нөгөө өмнөх төсвийнхөө

суурин дээр ингээд явчихъя гэдэг л үндсэн зохицуулалт. Өргөн барьснаас хойш ямар дэгээр хэлэлцэх вэ гэдэг бол Их Хурлын ажил. Тэгэхдээ тэрийг бид нар бас шууд зааж өгч болохгүй. Гэхдээ ямар ч байсан 12 сардаа багтаачихъя гээд ингээд хуульчлаад оруулж ирж байгаа юм. Их Хурал болон Их Хурлын Тамгын газар, холбогдох улсууд, Байнгын хороодтой ярилцсан. Ер нь амьдрал баян, ямар ч тохиолдол гарч болзошгүй. Тийм учраас ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Далайн Батбаяр гишүүн асуулт асууя.

Д.Батбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Яг би энэ Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэж байх үеийн Занданшатар даргын өгсөн тайлбарыг интернэтээс уншаад сууж байна л даа. Тэгэхээр ингэсэн байх юм. Манайх шиг уул уурхайн эдийн засагтай мөчлөг дагаж төсвийн хүндрэл бий болдог улсад алдагдалгүй төсөв батлах шаардлагатай. Хэрэв Ерөнхийлөгчийн тавьсан шаардлага хангагдахгүй бол дахин хориг тавихыг үгүйсгэхгүй ээ. Хууль, эрх зүйн хувьд боломжтой гэж байр сууриа илэрхийлж байсан байна л даа.

Тэгээд яг энэтэй холбоотойгоор энэ нөгөө төсөв, хуулийн энэ төсвийг санаачилж орж ирсэн ажлын хэсгээс бас асуумаар байна. Санал байна. Тэр нь юу вэ гэхээр 32-ын штрих 1, 3 дээр 8.4.5-д заасны дагуу өргөн мэдүүлсэн нэгдсэн төсвийн нийт зарлага болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлэхгүй гэж заасан байна. Энийг бууруулна гээд ороод ирэв, оруулаад ирвэл ер нь яасан юм бэ? Ер нь дараа дараадаа ийм жишиг тогтоогоод, энэ зардлаа, зарлагаа ер нь бууруулж орж байна гэсэн ийм хандлагаар, ийм байр сууриар бууруулна гээд яг энэ дээр ингээд оруулчихвал яасан юм бэ гэсэн нэг ийм санал бөгөөд асуулт байна.

32.1-ийн штрих 3.

Д.Амарбаясгалан: Далайн Батбаяр гишүүний асуултад Сангийн сайд Болдын Жавхлан сайдад хариулт өгөх үү?

Б.Жавхлан: Тийм, энэ Батбаяр гишүүн ээ, ийм юм байгаа юм аа. Үндсэн хууль дээр байдаг заалтыг л бараг энд орчихсон байгаа шүү дээ. Их Хуралд өргөн барьсны дараа Их Хурал дээр хэлэлцүүлэх явцдаа энийг муутгахгүй шүү л гэдэг санаа. Зардлыг нь бууруулж болохгүй, алдагдлыг нь нэмж болохгүй, муутгахгүй шүү гэдэг санаа. Их Хурал дээр хэлэлцэхдээ. Засгийн газар боловсруулахдаа энэ чинь өөр шүү дээ. Чиглэл авчихсан, ямар үндэслэлээр хууль нь хүчингүй болсон юм, тэрний чинь дагуу төлөвлөлт чинь. Их Хуралд өргөн барьсны дараа Их Хурал хэлэлцэхдээ тэр зардлыг нь нэмэхгүй, алдагдлыг нь нэмэхгүй, ингээд муутгахгүй шүү гэдэг санаа байхгүй юу. Тийм.

Д.Амарбаясгалан: Далайн Батбаяр гишүүн тодруулж асууя.

Д.Батбаяр: Ерөнхий санааг нь бол ойлгож байгаа сайд аа. Тэгээд нэгэнт нэмэхгүй гэж байгаа юм чинь тэгвэл бууруулна гээд ороод ирчих юм бол ядаж энэ Улсын Их Хуралд энэ 126 гишүүн байгаа шүү дээ, эд нарт маань бас нэг ингээд бууруулах чиглэл барьж байгаа юм байна гээд энэ нийгэмд нь бас зөв ойлголтоо оруулаад явчих юм биш үү. Тийм учраас бууруулна гээд оруулчихвал яасан юм гэсэн л санал яваад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд нэмж хариулах уу?

Б.Жавхлан: Тийм, Батбаяр гишүүн санал хэллээ гэж ойлголоо. Тийм, бүрэн эрхийнхээ хүрээнд зарчмын зөрөөтэй санал гаргаад хэлэлцүүлж болох байх аа. Тийм. Ер нь таны санаа бол сайжруулъя л гэдэг санаа байна шүү дээ. Оруулаад ирснээ сайжруулъя. Засгийн газар энэ удаа жишээ нь зардлыг нь бууруулаад оруулаад ирснийг нь Их Хурал дахиж элсэж байгаад дахиад бууруулъя л гэдэг санаа хэлэх гээд байна шүү дээ, та тийм ээ.

Д.Амарбаясгалан: Тэгээд гишүүд маань төсөв шинээр өргөөд баахан зардал танаад ороод ирсэн чинь тэр салбарын зардлыг танахгүй байсан юм гэдэг юмаа ярих вий дээ. Одоо яг энэ үгээ их сайн бодоцгооно шүү. Тийм. Дахиад хасъя гэж байгаа юм. Ер нь үргүй зардлыг бууруулах гэдэг бол зарчмын хувьд маш зөв. Яг бууруулах арга, боломж, нөхцөл нь Засгийн газрын түвшинд ямар хэмжээнд байгаа юм бэ гэдгийг бид бас салбарын яам, мэргэжлийн байгууллагуудаас мэдээж сонсох ёстой. Тэгээд баахан зардал бууруулаад ороод ирдэг, буцаагаад гишүүд маань тэр салбарын зардлыг бууруулж болохгүй байсан юм гэдэг юм болох вий дээ. Өнөөдөр хэд хэдэн гишүүний амнаас тийм үг гарч байгаа учраас энийг би бас гишүүддээ зориуд анхааруулж хэлж байгаа юм. Аливаа асуудалд бүгдээрээ их сайхан ажил хэрэгчээр хандана шүү.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналын томьёоллоор санал хураана. Зарчмын зөрөөтэй 3 санал байна. Зарчмын зөрөөтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж мөн аль нэг намын бүлэг, эвсэлд, намын бүлэгт харьяалалгүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно. Гишүүдийн нэр урьдчилсан байдлаар ирсэн байгаа. Гэхдээ эдгээр гишүүд зарчмын зөрөөтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн байдлаар үг хэлнэ гэдгийг дэгийн хуулиар тодруулсан байгаа гэдгийг бас хэлье.

Ингээд зарчмын зөрөөтэй саналын томьёоллыг танилцуулъя.

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томьёолол.

Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

1. Төслийн 1 дүгээр зүйл буюу 32¹ дүгээр зүйлийн 32^{1.5} дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32^{1.5}.Энэ хуулийн 32^{1.1}-д заасан төсвийн төслийг Улсын Их Хурал ажлын 7 хоногт багтаан, аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дээд шатны төсвийг баталснаас хойш ажлын 5 хоногт багтаан хэлэлцэж, дараагийн төсвийн ажил эхлэхээс өмнө батална.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал.

Батжаргал гишүүний микрофоныг өгье. Санал гаргасан гишүүн.

Ж.Батжаргал: Өргөн мэдүүлсэн төсөв дотор 3 шатны төсвийн эрх захирагч нар юу, төсвөө төсвийн жил эхлэхээс өмнө батлахаар ерөнхий цаглавартай ороод ирчихсэн юм. Тийм учраас тодорхой цаглавартай болгож, хугацаажуулах ёстой юм гэдэг байдлаар санал оруулсан. Төсвийн байнгын хороо дэмжсэн юм.

Гэхдээ сая би дахиж нягталж, Их Хурлын Хуулийн газар, Байнгын хорооныхоо зөвлөхүүдтэй санал солилцсон. Их Хурлын дэгийн тухай хууль болоод Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох заалтуудтай бас энэ гаргасан санал зарим талаар зөрчилдөж, эрсдэл дагуулж магадгүй тухай яригдаж байгаа юм аа.

Тийм учраас би энэ саналаа татъя гэж бодож байна. 1.

2 дугаарт, протоколд зориуд нэг 2 зүйлийг тусгаж оруулах зайлшгүй шаардлагатай байна.

1 дүгээрт, энэ хугацаажуулсан цаглаврыг ер нь баримжаалж, шат шатын хурлууд төсвөө хэлэлцэж батлах талаар анхаарах ёстой, 1.

2 дугаарт, сумын хурлууд дараагийн төсвийн жил эхлэхээс өмнө багтахгүй нөхцөл байдал үүсчихвэл 1 удаагийн үйлчлэлтэй эрх зүйн зохицуулалтыг Их Хурал гаргаж өгч, тэр эрх зүйн эргэлзээтэй байдал, эрсдэл, үр дагавраас нь гаргах ёстой. Үүнийг зориуд би протоколд тэмдэглүүлэх саналтай байна.

Ингээд гаргасан саналаа татаж байна.

Д.Амарбаясгалан: Ер нь зөв байх аа. Бас нарийвчилсан хугацаа оруулчихдаг. 7 хоногийн дотор Улсын Их Хурал маань хэлэлцэж баталж чадахгүй бол яах вэ. Цаашлаад орон нутгууд бас энэ дээр тэнд чинь мэдээж Засаг дарга, ИТХ, хурал дахь улс төрийн намын бүлгүүдийн байр суурь гээд их олон асуудлууд хөндөгддөгийг бид бас орон нутгийн төсвөө батлах, эрхээ хэрэгжүүлж байгаа Иргэдийн хурлын эрхэнд Улсын Их Хурлаас бас ингээд хамаагүй халдах нөхцөл бас байж болохгүй байх гэж ингэж бодож байгаа. Хуулиар хүлээсэн нийтлэг үүрэг хариуцлага байна шүү дээ. Төсвийн жилдээ багтах гэдэг асуудал байж байгаа. Тэгэхээр үүгээрээ зохицуулалт хийгээд явах нь зүйтэй байх гэсэн саналтай байна.

Ингээд Батжаргал гишүүн саналаа татлаа.

Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал.

2. Төслийн 1 дүгээр зүйл буюу 32¹ дүгээр зүйлийн 32^{1.2}, 32^{1.3} дахь хэсгийн “нэгдсэн” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа гишүүнд микрофон өгье.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Дэмжээгүй санал. Яагаад энэ саналыг гаргасан бэ гэхээр дэгийн тухай хуулийн 33-д зааснаар бид нар энэ хуулийг яаралтай горимоор хэлэлцэж байгаа. Яаралтай горимоор хэлэлцэж байгаа үед Улсын Их Хурлын Тамгын газар хууль зүйн дүгнэлт гаргаагүй байгаа гэсэн үг. Тийм учраас бид нар нэг үг, үсэг гэхээсээ илүү утга агуулгын хувьд бас харж, дараа нь бид нар бас яаралтай хугацаанд баталсан хууль, эрх зүйн орчин маань маргаан дагуулах ийм үндэс битгий болоосой гэж үзэж бас үг, үсэг дээр ч гэсэн анхаарах ёстой болов уу гэж оруулж байгаа юм. Яг энэ дээр яагаад “нэгдсэн” гэдгийг хасаж байгаа юм гэхээр “нэгдсэн төсөв” гэдэг ойлголт бол Төсвийн тухай хууль дээр тодорхой заагаад өгчихсөн. 21.1 дээр “нэгдсэн төсөв” гэдэг бол улсын төсөв, орон нутгийн төсөв, Ирээдүйн өв сан, Үндэсний баялгийн сан, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангаас бүрдэнэ гээд заагаад өгчихсөн байгаа. Төсвийн тухай хууль дээр.

Харин энэ нэмэлт дээр оруулж байгаа 8.4.5-ын дагуу гэж байгаа байхгүй юу. Гэтэл 8.4, төсвийн тухай хуулийн 8.4 маань нэгдсэн төсвийн тухай биш улсын төсөв болон дээр нь нөгөө сангуудын төсвийн талаар цаглаврыг тогтоож өгсөн байгаа. Үүний 8.4.5 нь бол Засгийн газар төсвийг өргөн барих энэ цаглаврыг тогтоож өгч байгаа. 8.5 дээр нь дангаараа харин улсын юу, орон нутгийн төсвийн асуудал байж байгаа гэсэн үг.

Тэгэхээр энэ төсвийн хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлт маань дэгийн тухай хуулиараа Үндсэн хуультайгаа, Үндсэн хуулийн зарчим буюу энэ төсвийн тухай хуулийнхаа зарчимтай нийцэж байх ёстой. Яг энэ агуулгаар би Төсвийн тухай хуультайгаа зөрчилдөж байна гэж үзэж байгаа.

Тийм учраас энэ юу 32-ын штрих 2, 32-ын штрих 3 дээр 8.4-д заасны дагуу өргөн мэдүүлсэн гэж тодотгож байгаа бол “нэгдсэн” гэдэг үгийг нь авах шаардлагатай байгаа юм. 8-ын дагуу өргөн мэдүүлсэн төсвийг үндэслэн боловсруулна л гэхэд боломжтой гэж үзэж байгаа юм. Ер нь Улсын Их Хурлын гишүүд бид хууль санаачлах, хууль батлахаас гадна хуулийн хэрэгжилтдээ хяналт тавьж байх ёстой. Тэгэхээр бид нарын энэ өргөн мэдүүлж орж ирж байгаа хуулийг батлах гэж байгаа энэ процесс маань яг тэр суурь хуулийнхаа концепц, зарчмыг, заалтуудыг зөрчөөгүй байх ёстой гэж үзэж энэ саналыг оруулж байгаа. Би уг нь энийг бас Сангийн яамтай ярьсан. Гэхдээ хуулийг бид нар өөр өөрсдийн ойлгож байгаагаараа тайлбарлаад баймааргүй байгаа юм. Улсын төсөв гэдэг дотор орон нутгийн төсөвт олгож байгаа татаас, орон нутгийн төсөвт олгож байгаа дэмжлэг, орон нутгийн сангийн мөнгө орчихсон учраас орон нутгийн төсөв орсон гэж үзнэ гээд байгаа юм. Гэтэл энэ хуулийн төсвийн тухай хуулийн нэр томъёоны хэсэг дээр улсын төсөв гэж юуг хэлэх юм, орон нутгийн төсөв гэж юуг хэлэх юм гэдгийг 4.1.6 болон 4.1.27 дээр заагаад өгчихсөн. Энэ 2 ялгаатай ойлголт.

Тийм учраас ингэж хольж, бас нэр томъёоны хувьд ингэж хэрэглэж боломгүй байгаа юм аа. Тэгээд сая Төсвийн байнгын хорооныхноосоо хүлцэл өчье. Бас орж тайлбарлаж танилцуулж чадаагүй учраас санал маань дэмжигдсэнгүй болов уу гэж бодож байна.

Ингээд эрхэм гишүүдийг энэ зарчмын зөрөөтэй саналыг дэмжиж өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: Байз энэ Тамгын газраас энэ нэгдсэн төсөв гэдгийн нэгдсэнийг авчихъя гэдэг санал явж байгаа шүү дээ. Тийм ээ. Энэ дээр Үндсэн хуулийн зөрчил үүсэх үү, үгүй юу. Энийг бас.

Сангийн сайд Болдын Жавхлан хууль санаачлагч энэ дээр тайлбар өгье.

Б.Жавхлан: Тийм, энэ дээр нэг их айхтар маргалдах асуудал биш, тийм. Одоо бид чинь ингээд төсвөө өргөн барьсан гэдэг дээр уншиж байхад бүгдээрээ анхааралтай сонсож байсан байгаа шүү дээ. Улсын төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, Ирээдүйн сангийн төсөв гээд. Энэ төсвүүд чинь тус тусдаа төсвүүд. Нийлүүлэхээрээ нэгдсэн төсөв. Энэ дээр бид нар ярилцаж байгаа. Энэ дээр ингээд дахиад орон нутгийн төсвүүд нэмэгдээд, Монгол Улсын нэгдсэн төсөв ингээд бүрддэг юм байгаа юм.

Тэгэхээр энэ нэгдсэн гэдэг төсөв маань яг өргөн баригдсан төсвөө нэрлэж байгаа учраас энийг хасчихаар нөгөө бусад сангуудын төсвүүд чинь ингээд гээгдчих учраас ингэж болохгүй. Тийм учраас ингээд нэгдсэнээр нь явчихъя. Энийг тэгэхдээ хаслаа гээд бас нэг их айхтар ач холбогдолтой зүйл болохгүй. Зарим нэг юм нь гээгдчих учраас бас дахиад бас үл ойлголцох асуудал үүсчих вий. Тэгэхээр энэ өргөн барьснаар нь явчихъя, Үүрийнтуяа гишүүн ээ. Уучлаарай.

Д.Амарбаясгалан: Санал гаргасан гишүүн Үүрийнтуяа гишүүнд микрофон өгье.

Д.Үүрийнтуяа: 8.4.5 дахь заалтаа аваад үзвэл тэнд яг одоо байгаа хууль. Би тэгээд нөгөө Үндсэн хууль гэдэг нь хурлын дарга аа, би суурь хуулиа ярьсан шүү. Төсвийн тухай суурь хуулиа ярьж байгаа шүү. Тэгэхээр 8.4.5 гэдэг энэ заалт дээр таны үндэслээд байгаа яг энэ заалт дээр Засгийн газар жилийн төсвийн төслийг ийм хугацаанд барина л гэж байгаа юм. Түүн дээр нэгдсэн төсөв гэдэг үг, үсэг ойлголт байхгүй. Харин төсвийн тухай хууль дээрээ бид нар нэгдсэн төсөв гэдгийг орон нутгийн төсөв орсноороо ойлгоно. Улсын төсөв гэдэг бол орон нутгийн төсвийг оруулаагүй дүнгээр, оруулаагүйгээр томъёолоод өгчихсөн байгаа байхгүй юу. Тэгээд яах вэ, зүгээр хэдийгээр жижиг асуудал гэж нэг талаасаа нэг үг, үсгийн юм шиг харагдаад байгаа болов ч цаанаа бид нар яг энэ төсвийн тухай хуулиа зөрччихсэн юм шиг ийм заалтууд оруулчих вий дээ.

Нөгөө талдаа орон нутгийн төсөв гээд оруулчих юм бол орон нутгийн төсвийн бас яг энэ алдагдалгүй хэмжээгээр батлах асуудал үүсчхэж байгаа байхгүй юу. Тэгээд энэ төсвийн тухай хуульдаа ч биш, ер нь нэг зарчмын юмыг бас энэ дээр санал болгоод нэмээд хэлчихье дээ. Гишүүд бол янз бүрийн зарчмын зөрөөтэй саналуудыг гаргаж байгаа. Тэгээд энэ дээр үнэхээр магадгүй миний энэ санал үндэслэлгүй бол тэрийг яг хууль зүйн үүднээс нь тайлбарлаад өгчихмөөр байгаа юм. Үндэслэлтэй байгаад, миний тэр тодорхойлоод байгаа зүйлийг няцааж чадахгүй бол авчихдаг баймаар байгаа юм. Гишүүд нэг санал гаргадаг, тэр ямар ч үнэ цэнгүй яригдаад л өнгөрдөг. Тэгээд эргээд нөгөө энэ зөрчил бидний хоорондох үл ойлголцол юунаас үүсээд байна гэхээр ийм л зүйлээс ер нь үүсээд байгаа шүү дээ.

Тэгээд хэлж ярьж байгаа асуудлууд, гишүүдийн тавьж байгаа саналууд, яг бодитой байгаа бол бодитой нөхцөл байдлаа гаргаад хэлчихмээр байна. Түүнээс хуулийг хэдүүлээ өөр өөрсдийнхөө ойлгож байгаагаар тайлбарлаад баймааргүй байна. Би энэ хууль дээр ёстой цагаан дээр хараар биччихсэн үг, үсгийг л уншаад байгаа юм. Тэгээд энэ би буруу ойлгоод байгаа бол магадгүй энэ хуулийг би буруу хэрэглээд байгаа бол надад тэрийг тайлбарлаад өгчих.

Д.Амарбаясгалан: Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа тайлбар хийлээ. Санал хураалт.

Томъёоллыг дахиж уншъя.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал.

2. Төслийн 1 дүгээр зүйл буюу 32¹ дүгээр зүйлийн 32^{1.2}, 32^{1.3} дахь хэсгийн “нэгдсэн” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

55,2 хувиар Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдлээ.

3. Төслийн 1 дүгээр зүйл буюу 32¹ дүгээр зүйлийн 32^{1.4} дэх хэсгийн “8.4, 8.5 дахь хэсэг” гэснийг “8.4, 8.5 дахь хэсэгт заасан хугацаа,” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяад микрофон өгье.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. 8.4. 8.4 дэх заалтад зөвхөн Засгийн газар төсөв өргөн барихаас гадна Үндэсний аудитын газар тухайн жилийн төсөвт аудит хийж, дүгнэлтээ Улсын Их Хуралд танилцуулах дүгнэлтийг хүргүүлэх цаглавар, нөгөө талдаа олон нийтэд мэдээлэх үүрэг нь хамт явж байгаа. Мөн дараа нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг гаргах. Энэ гаргасан дүгнэлтээ Улсын Их Хуралд хүргүүлэх цаглавар, дээр нь бас олон нийтэд мэдээлэх чиг үүрэг нь явж байгаа юм. Тэгэхээр 8.4, 8.5 дахь хэсэг хамаарахгүй гэхийгээр энэ өөрөө одоо энэ орж ирж байгаа төсөвт аудит хийгдэхгүй юм шиг. Хийгдлээ гэхэд хийгдсэн аудит нь олон нийтэд танилцуулагдахгүй юм шиг нэг ийм нөхцөл байдал харагдаад байгаа юм аа.

Тэгээд гол нь энд өөрчлөх гээд байгаа энэ зүйл хамаарахгүй гэж оруулаад байгаа санаа нь бол энэ цаглаварыг л хамаарахгүй байхаар оруулах гээд байгаа санал шүү дээ. Цаглавар буюу хугацааг. Тийм учраас яг энэ 8.4, 8.5-д заасан асуудал. 8.5 бол тэр чигтээ орон нутгийн асуудал байгаа. Орон нутгийн төсөвтэй холбоотой цаглавар байгаа. Тэгэхээр энэ цаглаваруудын хугацааг нь тооцохгүй, бусад чиг үүргүүд нь байхаар үлдээхгүй бол үүнийгээ аваад хаячхаж бас болохгүй байх гэж харж байгаа. 28-ын штрих дээр олон нийтийн хэлэлцүүлэг байгаа. Ерөнхий агуулга энэ хуулийн төслийн үзэл санаа нь олон нийтийн хэлэлцүүлгийг өмнө хийчихсэн зүйл дээр дахиж оруулахгүй. Дээр нь бас тодорхой хэмжээний хэлэлцүүлгүүд энэ дунд өрнөөд энэ төсөв хүчингүй болж байгаа учраас дахин хэлэлцүүлэг хийх шаардлагагүй гэдэг концепцоороо үүнийг бүхэлд нь хасаж байна гэж ойлгож байгаа. Хамааруулахгүй байхаар оруулж байгаа юм байна гэж ойлгож байгаа.

Тэгэхээр энэ дээр тодорхой цаг хугацаа гэдгийг нь зааж өгөхгүй бол бусад чиг үүргүүд ялангуяа олон нийтэд мэдээл чиг үүргүүд нь үүнийгээ дагаад байхгүй болчих вий гэдэг ийм болгоомжлол байгаа учраас ингэж оруулсан юм байгаа юм.

Д.Амарбаясгалан: 3 дахь санал хураалт. Дахиж уншиж танилцуулъя.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал.

Төслийн 1 дүгээр зүйл буюу 32¹ дүгээр зүйлийн 32^{1.4} дэх хэсгийн “8.4, 8.5 дахь хэсэг” гэснийг “8.4, 8.5 дахь хэсэгт заасан хугацаа,” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа. Санал хураалт.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал 49,5 хувиар дэмжигдсэнгүй.

Тэгэхээр санал гаргасан гишүүний санал боссон гэсэн үг.

Батмөнхийн Батцэцэг сайд горимын санал.

Б.Батцэцэг: Ажилласангүй, төхөөрөмж ажилласангүй, Их Хурлын дарга аа, дахин санал хураалт хийлгэх саналтай байна.

Д.Амарбаясгалан: Байз, горимын санал гаргаж байна.

Тэгвэл Батмөнхийн Батцэцэг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна.

Би гишүүддээ зориуд нөхөрсөг байдлаар нэг зүйлийг зөвлөө. Бид энэ Улсын Их Хурлын нэр хүндийг хадгалж, хамгаалах үүрэгтэй гишүүд ээ. Санал өгч чадаагүй, өөрөөс шалтгаалсан алдааг Улсын Их Хурлын үйл ажиллагаа, санал хураадаг төхөөрөмжтэй холбож, тайлбар хийдгийгээ одоо бүгдээрээ ёс зүйн хувьд больё. Би хурууныхаа хээг уншуулж чадсангүй. Санал хураалтаас хоцорлоо гэдгийгээ үнэн мөнөөр нь хэлж байна. Ингэхгүй бол ард иргэдийн зүгээс энэ Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагаа, Их Хурлын санал хурааж байгаа техник технологи болдоггүй гэсэн нэг ийм нийтлэг ойлголт авч байгаа гэдгийг та бүхэн бүгдээрээ хариуцлагатайгаар ойлгож, ухаарч, асуудалд хариуцлагатай хандахыг хүсье ээ.

Ингээд горимын санал гаргасан Батмөнхийн Батцэцэг сайдын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Батцэцэг сайдын гаргасан горимын саналаар 53,3 хувиар түрүүчийн санал хураалт хүчингүй боллоо.

Техникийн албаны хүн байвал Батцэцэг гишүүний төхөөрөмж дээр очиж зөвлөгөө өгье. Тэгээд санал хураалт явуулъя.

3 дахь санал хураалтаар Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

49,5 хувиар санал дэмжигдсэнгүй ээ.

Батсуурь сайд. Миний, би бас хурууныхаа хээг уншуулж чадсангүй, хэрүүл хийж сууж байгаад. Батсуурь сайд.

Ж.Батсуурь: Энэ хурууныхаа хээг уншуулж амжсангүй ээ. Тэгээд дахин санал хурааж өгнө үү.

Д.Амарбаясгалан: Хэдэн гишүүн санал өгч чадсангүй вэ. Дэмжсэн мөртөө санал нь тоологдоогүй 1, 2, 3, 4, 5. 5 гишүүн байна. Гэхдээ энэ дээр шууд нөгөө 49,5 хувь гээд гарчихсан учраас 5 гишүүн дэмжээд, санал дэмжигдсэн гэж унших боломжгүй. Яагаад гэхээр төхөөрөмж дээр протоколд орж байгаа. Тэгээд энэ тийм чухал асуудал юм уу. Хугацаа гээд орчихоор асуудал үүсэх асуудал юм уу.

Тэгвэл Батсуурь сайдын горимын саналыг сонсьё. Юу, горимын саналаар санал хураалт явуулъя. Сүүлийн удаа. Санал хураалтыг. Горимын санал л хэлнэ. Батсуурь сайдын гаргасан горимын саналаар санал хураалтыг дахин хүчингүй болгох асуудал. Сүүлийн удаа санал хураалт явуулж байна. Санал хураалт.

54,3 хувиар Батсуурь сайдын гаргасан горимын санал дэмжигдлээ.

3 дахь санал хураалтаар Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

57,1 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд зарчмын зөрөөтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

12.58 цаг

Байнгын хороо шууд хуралдана. Удах юм уу.

Байнгын хороо хуралдах учраас Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг 10 минут завсарлууллаа. 10 минут.

ЗАВСАРЛАГА

Д.Амарбаясгалан: Хуралдаан үргэлжилье.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

3 дахь асуудал.

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Тилеуханы Аубакир танилцуулна. Индэрт урьж байна.

Т.Аубакир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн. Төсвийн байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авсан бөгөөд нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр хэлэлцлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хувилбарын төсөл, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Аубакир гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Баярсайханы Солонго ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэгт болон бүлэгт харьяалалгүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн. Алга байна.

Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууна.

Л.Мөнхбаясгалан: Хавдар судлалын эмнэлэг дээр 2025 оны улсын төсөвт ерөөсөө мөнгө тавиагүй. 2024 онд эмнэлгийн барилгын зургийг тендерийг зарлаад компани шалгарахгүй байж байгаад Буд компани шалгарсан байдаг. 3 тэрбум. Хавдрын эмнэлгийн зургийг хийнэ гэдэг бол баргийн компани хийж чаддаггүй тусгай зориулалтын тийм зураг байдаг. Тэгээд үнийн дүн нь бага учраас бас компаниуд оролцдоггүй ээ.

Тэгэхээр бид нар 2025 онд дахиад Хавдрын эмнэлэг дээр мөнгө тавиулахгүй бол бүтэн нэг жил өнжих гээд байгаа юм. Бүтэн нэг жилийн дотор 4500 хүн нас барна. Үүнээсээ ч нэмэгдэх магадлалтай. Тэгэхээр Монголын төр өнөөдөр нэг жилийг 4500 хүн нас барж байхад тоохгүй мөнгө тавихгүй байж ерөөсөө болохгүй байгаа юм аа. Тийм учраас гишүүдээр дэмжиж гарын үсэг зуруулаад яваад байгаа. Энэ бол ...

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууна. Мөнхбаясгалан гишүүний саналыг бүрэн илэрхийллүүлээ.

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууна. Алга байна.

Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууна. Алга байна.

Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууна. Алга байна.

Жуковын Алдаржавхлан гишүүн асуулт асууна.

Ж.Алдаржавхлан: Би түрүүн асуулт асуух гэж байсан, хоцроод асууж чадаагүй юм. Тэгэхдээ 1 зүйлийг энэ протоколд зайлшгүй тэмдэглүүлье. Түрүүн тэр Батжаргал гишүүний гаргасан санал уг нь зөв байсан юм. Орон нутгийн төсвийг төсвийн жилд багтааж батална гэдэг үг өөрөө хэзээ ч байж болно гэсэн үг байгаа юм. 12 сарын 31-нд батална ч гэсэн үг байгаа юм. Тэгэхээр аймаг, орон нутгууд чинь улс төр маш их болчихсон. Батлахгүй байж байгаад он дамжуулаад нутгийн хурал тарах асуудал руу орж магадгүй байгаа учраас энэ тодорхой хугацаа тавьж өгсөн бол уг нь зөв байсан юм аа. Би Батжаргал гишүүний түрүүнийхээ саналыг уг нь татахгүй байж байгаад 12 сарын 25-ны дотор ч юм уу батална гэсэн тийм нэг заалт бол зайлшгүй оруулж өгөх ёстой байсан юм гэдэг бас саналаа нэгд хэлчихье.

2 дугаарт нь, энэ алдагдалгүй батлах ёстой гээд нэг ийм сонин заалт орж ирсэн байгаа. Ер нь бид нар энэ хоригт, зөвхөн хоригийг бодоод байгаа байхгүй юу. Цаашдаа бид нар төсөв ер нь ингээд янз бүрийн улс төрийн шийдвэрээр хүчингүй болсон нөхцөлд заавал алдагдалгүй батална гэдэг чинь өөрөө эдийн засгаа боомилсон асуудал биш биз дээ. Энийгээ эргэж хараад явахгүй юм уу. Алдагдалгүй батлаарай л гэсэн ийм хатуу тийм юм руу явчихсан байна лээ шүү дээ. Ирээдүйд алдагдлаа нэмээд, орлогоо дайчилъя гэсэн санал гарвал яах вэ. Төсөв хүчингүй болгоод. Тэгвэл тэр юуг нээж өгч болоогүй юм уу гэсэн асуултыг энэ Байнгын хорооны даргаас асууя.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн хариулъя.

Ц.Даваасүрэн: Алдаржавхлан гишүүн бас энэ саналаа бидэнд хэлсэн юм аа. Тэгээд нэгэнт нөгөө Батжаргал гишүүн саналаа татчихсан учраас энэ санал тэгээд татагдчихлаа. Зүгээр ер нь би бас санал нэг байгаа юм. Хугацаа тавьж хариуцлагажуулъя гээд байгаа юм. Тэгэхдээ ер нь би бүх шатны төсвийнхөн манай Их Хурал ч гэлээ гэсэн бас энэ дээр, энэ асуудал дээр хариуцлагатай хандах байх. Бид нар иргэдийнхээ өмнө ондоо багтаж төсвөө батлах ёстой.

Тийм учраас дараагийн шатны төсвөө бид нар төсөв батлах хугацааг анхаарах зайлшгүй шаардлагатай. Бид нар 12 сарын 10, 12 гэхэд төсвөө баталсан байх ёстой. 20-ны дотор аймгууд баталсан байх ёстой. Тэгээд дараа нь нэг 5 хоногийн дотор сумд баталсан байх ёстой гэсэн ийм л хугацаагаар явъя гэж тогтож байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Алдагдалтай төсөв батлахгүй гэсэн заалт байгаа гэж асууж, тийм заалт байхгүй шүү дээ, тийм ээ.

Жуковын Алдаржавхлан гишүүн тодруулж асууя.

Ж.Алдаржавхлан: Энд нэг ийм заалт байгаад байна шүү дээ, Даваасүрэн дарга аа. Хэрвээ дахин өргөн мэдүүлэхээр болсон бол нэгдсэн төсвийн нийт зарлага алдагдлын хэмжээ нэмэгдүүлэхгүй байна гэж байна шүү дээ. Хориг юм уу ямар нэгэн хэлбэрээр дахиад өргөн баригдах юм бол, хүчингүй болоод. Тэгэхээр чинь ер нь ямар, ирээдүйд янз бүрийн асуудлууд үүсээд, алдагдлаа нэмээд, орлогоо дайчил гэсэн шийдвэрээр Ерөнхийлөгч хориг тавивал яах вэ, жишээ нь. Тэгэхээр ер нь энэ алдагдалгүй зарлагаа нэмэгдүүлэхгүй гэж хатуу энэ заах нь зөв байсан юм уу гэдэг асуудал байгаа юм. Энэ дээр нэг хариулж өгөөч.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Алдаржавхлан гишүүн ээ, энэ төсвийн нийт зарлага болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлэхгүй хэлэлцэнэ гэдэг нь Үндсэн хуулийн заалт юм. 19 онд Үндсэн хуульд хийхдээ энэ заалтыг оруулсан. Тийм учраас бид нарыг хэлэлцүүлэх явцдаа Үндсэн хуулийнхаа энэ заалтыг дагаарай л гэсэн ийм заалт юм байгаа юм.

Д.Амарбаясгалан: Пүрэвдаваа гишүүн асуулт асууна. Алга байна.

Жадамбаагийн Баясгалан гишүүн асуулт асууна. Алга байна.

Загджавын Мэндсайхан гишүүн асуулт асууна. Алга байна.

Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

13.18 цаг

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д 7 хоногийн Баасан гарагийн 10 цагт нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Хуралдааны ирц хуулийн төсөл эцэслэн батлах шаардлага хангахаар бол бусад өдөр, цагт хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулж болно гэж заасны дагуу Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах хувилбарыг Төсвийн байнгын хороо бэлтгэж, эцэслэн батлуулахад бэлэн болсон байна.

Одоо төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулна.

Улсын Их Хурлын гишүүдийг чуулганы танхимд орж ирж, санал хураалтад оролцохыг хүсэж байна. Ирцийн санал хураалтыг нэг явуулаадахъя. Ирц, ирцийн санал хураалт.

Санал хураалтад 53 гишүүн оролцсон байна. Санал хураалтад оролцож чадаагүй гишүүд байна уу? 1, 2, 3, 4, 5, 6, 7.

7 гишүүн гэдэг чинь 60 гишүүн байна гэсэн үг. Гишүүдийг дуудъя.

Энэ хооронд Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн бас энэ санал хураалт, төхөөрөмжтэй харилцах талаар багахан зөвлөмж өгөөдөхье гээд тэгсэн. Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүнд микрофон өгье.

Санал хураалттай, дэг байхгүй гэж байна. Дараа нь больё, дэг байхгүй гэж байна.

61 гишүүн боллоо, 62 гишүүн боллоо. Нэлээн хэдэн гишүүн ороод ирлээ. Ахиад ирц бүртгэлийн санал хураалтыг нэг явуулж үзье. Ирц бүртгэлийн санал хураалт.

Санал хураалтад орж чадаагүй гишүүд байна уу? 1, 2, 3.

Ингээд танхимд 70 гишүүн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан. 64 гишүүнээр дэмжигдэнэ гэсэн үг.

Санал хураалт.

1. Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

77 гишүүн буюу нийт гишүүдийн олонх дэмжлээ. Хуулийн төсөл батлагдлаа.

13.20 цаг

Одоо батлагдсан хуулийн эцсийн.

Төсвийн байнгын хорооны дарга Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн горимын санал гаргаж байна.

Ц.Даваасүрэн: Их Хурлын дарга аа, Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл эцэслэн батлагдсан учраас **эцсийн найруулгыг сонсчихъё.**

Д.Амарбаясгалан: Даваасүрэн гишүүний гаргаж байгаа горимын саналаар батлагдсан хуулийн эцсийн найруулгыг сонсох уу? Гишүүд татгалзаж байгаа гишүүн байна уу? Алга байна.

Тэгвэл Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

13.24 цаг

Өнөөдрийн нэгдсэн хуралдаан хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ